Дээлэнд нэг заам байдаг, гэрт нэг тэргүүн байдаг

Монгол ардын сургаал үг

МОНГОЛ УЛСЫН ЗГМ ШИЛДЭГ СОНИН

ЗАСГИЙН ГАЗРЫН МЭДЭЭ

2018.12.14, БААСАН ~ №243 (1042) ~ СОЁЛТ ХҮНИЙ ӨГЛӨӨ СОНИН УНШИХААС ЭХЭЛДЭГ ~ ҮНЭ: 1000₮

АНУ-ын зэвсэгт хүчний хошууч нас барсан байдалтай олдлоо
ЭСЯ-ныхан БХЯ-тай хамтран бүх асуудлыг шийдвэрлэхээ мэдэгдэв. > 3

Б.Ану-Үжин: Үнэртэй усны суурь үнэр хамгийн чухал
Цаашдаа төрөл бүрийн гоо сайхны бүтээгдэхүүн зохион бүтээнэ гэж боддог. > 4

Алтны ил тод байдал хумигдаж болзошгүй
Төв банкны алт худалдан авалт 19.8 тоннд хүрчээ. > 11

ZGM DAILY
FULL ENGLISH PAGE INSIDE > 7

ОНЦЛОХ

УЛС ТӨР

Сайд Ө.Энхтүвшин БНХАУ-ын Зах зээлийг хянан зохицуулах газрын даргыг хүлээн авч уулзав.

Ирц бүрдээгүй гэсэн шалтгаанаар парламентын үйл ажиллагаа дахин гацав.

Ардчилсан нам УИХ, Засгийн газраас төрийн ажлыг гацаалгүй явуулахыг шаардлаа.

Л.Энх-Амгалан: Цэц ЗГ-ыг Үндсэн хууль зөрчсөн гэж үзвэл огцрох үндэслэл бүрдэнэ.

ЭДИЙН ЗАСАГ

Монголбанк 20 тонн алт худалдан авсан нь өнгөрсөн оны мөн үеэс гурван хувь өссөн дүн юм.

А.Суарат: Тавантолгойн цахилгаан станц барихад ЗГ-тай ойлголцох асуудлууд байна.

"Говь" ХК-ийн хувьцаа хуваах өөрчлөлтийг бүртгэсэн тул арилжааг өнөөдөр нээнэ.

Топ 20 индекс 1.12 хувиар өсч, 19672.25 нэгжид хүрэв.



НИЙГЭМ

Дархан-Уул аймгаас хүүхэд хулгайлахыг завдсан эмэгтэйд гурван жилийн ял оноолоо.

НИТХ-ын даргын өрөөнд төлөөлөгчид зодолдсон гэх мэдээллийг Ажлын алба нь үгүйсгэв.

Нийслэлд мал аж ахуй эрхлэхийг хориглох бүсийн хил хязгаарыг нэмэгдүүлжээ.

ЭМЯ: Хүүхдийг агаарын бохирдлоос хамгаалахын тулд маск зүүлгэх шаардлагатай.

ДЭЛХИЙ

ОХУ-ын газрын тос олборлолт 2019 онд өсөх тооцоог ОПЕК гаргаад байна.

"Умард урсгал – 2" төслөөс татгалзахыг Европарламент гишүүн орнуудад уриалав.

Трампын зөвлөх асан М. Коэн луйврын хэргээр гурван жил хоригдох ялаар шийтгүүллээ.

Шинэ Samsung Galaxy S10 загвар Apple-ын iPhone-оос үнэтэй гарна.

ЦАГ АГААР

УЛААНБААТАР
2018.12.14

-11° -19°

БАГАВТАР ҮҮЛТЭЙ

ЦАГ АГААРЫН ДЭЛГЭРЭНГҮЙ МЭДЭЭЛЛИЙГ 8 ДУГААР НҮҮРЭЭС УНШИНА УУ.

8 658000 029112 01042

Бүх эрх хуулиар хамгаалагдана ©

У.ХҮРЭЛСҮХ, ШИНЗО АБЭ НАР ХАМТАРСАН МЭДЭГДЭЛ ГАРГАВ

Хоёр орны Засгийн газрын түвшинд шинэ нисэх буудлыг ашиглалтад оруулах, ХАА-н бүтээгдэхүүн үйлдвэрлэх, ноолуур экспортлоход Японы хөрөнгө оруулалтыг нэмэх, Монгол Улсад аялал жуулчлалыг хөгжүүлэх, бүс нутгийн энх тайван байдлыг хангахад нягт хамтарч ажиллахаар боллоо. ▶ 2

ЗГМ©

УЛС ТӨР

УБЕГ, ШШГЕГ нь Засгийн газрыг хууль зөрчсөн нөхцөл рүү түлхэж байна

Г.Илч
ЗГМ

Улсын дээд шүүхээс энэ оны есдүгээр сарын 19-нд "Эрдэнэт үйлдвэр", "Монголросцветмет" нэгдлийн эзэмшлийн маргааныг хэлэлцээд, "Монголын зэс" корпорацын талд эцэслэн шийдвэрлэсэн. Тэгвэл хүчин төгөлдөр шийдвэр гараад гурван сарын хугацаа өнгөрөөд буй энэ үед Улсын дээд шүүхийн тогтоолын биелэлт хэрхэн хэрэгжиж буйг "Монголын зэс" корпорацын гүйцэтгэх захирал Ц.Пүрэвтүвшингээс тодрууллаа.

-Улсын дээд шүүхийн шийдвэр гараад хэдийн гурван сарын хугацаа өнгөрлөө. Энэ хугацаанд "Эрдэнэт үйлдвэр", "Монголросцветмет" нэгдлийн 49 хувийн эзэмшлийг эцэслэн шийдсэн Дээд шүүхийн шийдвэр хэрхэн биелж байна вэ?

-Дээд шүүхээс "Эрдэнэт үйлдвэр", "Монголросцветмет" нэгдлийн 49 хувийн эзэмшлийн маргааныг энэ оны есдүгээр сарын 19-нд эцэслэн шийдвэрлэж, хууль ёсны хувьцаа эзэмшигч нь "Монголын зэс" корпорац гэж үзсэн. Шүүхийн шийдвэр гараад бараг гурван сарын хугацаа өнгөрч буй ч хэрэгжилт нь гацаад байна.

▶ 2

ЭДИЙН ЗАСАГ

Хятадын баячуудын оффшор хуримтлал $1 их наядад хүрлээ

Хун Жиньшань

Хятадын баячууд ирэх сараас хэрэгжих оффшор хөрөнгөтэй холбоотой заалт бүхий татварын шинэ зохицуулалтаас урьтаж хөрөнгөө гадаадын траст компани, сангуудад шилжүүлэхээр уралдаж эхэллээ.

Оффшор траст сонирхогч хятад үйлчлүүлэгчийн тоо энэ оны сүүлийн хагаст 35 хувиар өссөнийг Bank of Singapore-ын активын төлөвлөлт хариуцсан тэргүүн Ли Вун Шю тайлбарлаж байна. Хөндлөнгийн итгэмжлүүлэгч (trustee) нарт "татвар төлөвлөлтийн боломж" олгохуйц траст байгуулахтай холбоотой лавлагаа хүсэх нь наймдугаар сараас хойш хоёр дахин ихэссэнийг ч тэрбээр нэмж өгүүлэв.

Ирэх оны нэгдүгээр сарын 1-нээс хүчин төгөлдөр үйлчлэх зохицуулалтаар Хятадын бага, дунд орлоготой хэсгийн татварын дарамт хөнгөрч, баян чинээлэг хэсэг ахиу татвар төлдөг болно.

▶ 9

ЗГМ: ИНФОГРАФИК

ЭДИЙН ЗАСАГ

Хөрөнгө оруулалтад халтай шийдвэр гарах эрсдэл өндөр байна

Б.Баяртогтох
@bayartogtokhZGM

Монголын нөлөө бүхий эдийн засагчид ирэх оны төсөв, мөнгөний бодлогын хүрээнд үүсэж болзошгүй эрсдэлийг дор бүрнээ урьдчилан таамаглаж, өөрсдийн байр сууриа нэгтгэн төсөв, мөнгөний бодлогыг тодорхойлох төрийн байгууллагуудад гардууллаа. 2019 оны эдийн засагт ноёлох голлох эрсдэлийг Bloomberg TV Mongolia-ийн дэргэдэх эдийн засагчдын клубийн шинжээчид эрэмбэлж, төсвийн орлого төлөвлөсөн хэмжээнд хүрэхгүй байх эрсдэл бодитой оршиж байгааг юуны өмнө анхааруулав.

Үндэсний статистикийн хороо энэ оны арваннэгдүгээр сарын нийгэм, эдийн засгийн ээлжит тайлангаа танилцуулж, одоогийн нөхцөл байдлыг олон нийтэд тоогоор дамжуулан хүртээл болгоод байгаа. Энэ үед ирэх онд анхаарах эрсдэлүүдийг улсын төсөв тэргүүлж, валютын ханшийн "халуурал" залгаж байна.

Статистик үзүүлэлтээс харахад, энэ оны төсвийн орлого 1.7 орчим их наяд төгрөгөөр давж, төлөвлөсөн орлого тасрах эрсдэл нэгэнт мартагдсан.

▶ 12

АЛТ	ЗЭС	10-ЧИНГИС БОНД	ХУРАЛДАЙ БОНД	ГЭРЭГЭ БОНД	АМ.ДОЛЛАР	ЮАНЬ	РУБЛЬ
1245.04 0.05%	6140 0.45%	94.26 00.00%	107.52 0.1%	95.63 0.16%	2635	383.62	39.77

NNC NATIONAL NEWS CORP | БҮРЭЛДЭХҮҮН КОМПАНИ | THE OFFICIAL GAZETTE

ubinfo.mn

Улс төр

У.Хүрэлсүх, Шинзо Абэ нар хамтарсан мэдэгдэл гаргав

Ерөнхий сайд нар 19 сэдвийн хүрээнд яриа хэлэлцээ хийжээ

П.Батбөх
ЗГМ

Япон улсад албан ёсны айлчлал хийж буй Ерөнхий сайд У.Хүрэлсүх өчигдөр тус улсын Засгийн газрын тэргүүн Шинзо Абэтэй албан ёсны уулзалт хийжээ. Хоёр улсын Ерөнхий сайд нар Монгол, Японы харилцааг улс төр, нийгэм, эдийн засаг, батлан хамгаалах, соёл, боловсрол, спортын зэрэг бүхий л салбарт улам өргөжүүлж, стратегийн түншлэлийг бэхжүүлэх талаар дэлгэрэнгүй ярилцаж, санал солилцсон байна. Мөн Эдийн засгийн түншлэлийн хэлэлцээр буюу чөлөөт худалдааны хэлэлцээрийн хэрэгжилтийг ярилцсан. Албан ёсны хэлэлцээрийн дараа хоёр улсын Ерөнхий сайд хамтарсан мэдэгдэл гаргасан юм.


ЗГМ©

Тус мэдэгдлийн эхэнд Ерөнхий сайд У.Хүрэлсүхийн Япон Улстай харилцаа, хамтын ажиллагаагаа улам бүр гүнзгийрүүлэн хөгжүүлэх эрмэлзлээ нотолсныг чухалчилж, Монгол орны орчин үеийн хөгжлийн суурийг тавихад чухал ач холбогдол үзүүлсэн Япон улсын Засгийн газар, ард түмэнд гүн талархал илэрхийлсэн талаар дурдсан байна. Мөн Шинзо Абэ Японд болсон байгалийн гамшигт Монголын төр засаг, ард түмэн халуун дотно илгээлтээр дэмжсэнд талархал илэрхийлснийг онцолжээ.

Хамтарсан мэдэгдлийг 19 сэдвийн хүрээнд хийсэн бөгөөд тэднээс онцлон дурдвал шинэ нисэх буудлыг ашиглалтад оруулах, ХАА-н бүтээгдэхүүн үйлдвэрлэх, ноолуур экспортлоход Японы хөрөнгө оруулалтыг нэмэх, бүс нутгийн энх тайван байдлыг хангахад нягт хамтарч ажиллахаар болсон байна. Тухайлбал, Хөшигийн хөндийн олон улсын нисэх онгоцны шинэ буудлыг ирэх онд багтааж шуурхай ашиглалтад оруулах чиглэлээр манай Засгийн газар ажиллаж байгаагаа илэрхийлсэн бол Японы Засгийн газар нисэх онгоцны буудлын аюулгүй үйл ажиллагааны менежментийг хангахаар ажиллаж буй Японы консорциумын үйл ажиллагааг үргэлжлүүлэн дэмжих эрмэлзэлтэй байгаа аж. Мөн хоёр улсын Ерөнхий сайд нар Монголын эдийн засгийг төрөлжүүлэхэд хөдөө аж ахуйн салбарыг улам бүр хөгжүүлэхийн чухлыг онцолж, "Хөдөө аж ахуйн салбарыг тогтвортой хөгжүүлэх замаар нэмүү өртгийн сүлжээг бий болгох мастер төлөвлөгөө" төслийг хэрэгжүүлэхээр албан ёсоор шийдвэрлэснийг зарласан байна. Түүнчлэн бүс нутгийн аюулгүй байдлыг хангах "Чөлөөт, нээлттэй Энэтхэг, Номхон далай"-г цогцлоох үзэл санаанд Монголын тал идэвхтэй оролцох хүсэлтэй байгааг илэрхийлж хоёр тал хамтран ажиллахаар санал нэгдсэн байна. Монголын талд үр өгөөжөө өгөх бас нэгэн чухал хэлэлцээр болсон нь Монгол Улсад аялал жуулчлалыг хөгжүүлэхэд хоёр орны төр, хувийн хэвшлийн хамтын ажиллагааг эрчимжүүлэхээр болсон явдал байв.

Ийнхүү хоёр улсын Засгийн газрын тэргүүнүүд тохиролцсон яриа, хэлэлцээрээ мэдэгдлээр баталгаажуулж, Монгол, Японы Стратегийн түншлэлийн Дунд хугацааны хөтөлбөрийн хэрэгжилтийн тухай танилцуулжээ.

1990 оноос өнөөг хүртэлх хугацаанд Япон Улсаас Монголд худалдаа, нийтийн хоол болон уул уурхай, банк, санхүү, аялал жуулчлал, барилга, мэдээллийн технологийн салбарт нийт 716 сая ам.долларын шууд хөрөнгө оруулалт хийгдсэн байна. Харин энэ оны аравдугаар сарын байдлаар Монгол-Японы худалдааны эргэлт 496 сая ам.доллар байжээ. [ЗГМ]

М.Энхболдыг УИХ-ын даргаас чөлөөлөхийг хүсэгчид ҮАБЗ-д хандлаа

УИХ-ын дарга М.Энхболд чуулганы хуралдааныг ирц хүрээгүй шалтгаанаар хойшлуулсан бол түүнийг албан тушаалаас нь буулгахыг хүсэгчид тэмцлээ гудамжнаас үргэлжлүүлэхээ мэдэгдлээ. Мөн М.Энхболдыг УИХ-ын даргаас чөлөөлөх өргөдлөө өгөхийг шахаж буй гишүүдийн тоо 38 болж нэмэгдээд байна. Ингэснээр 75 гишүүнтэй парламентад эл асуудлаар олонх болжээ.

Тэднийг төлөөлж Х.Нямбаатар, Л.Оюун-Эрдэнэ, Т.Аюурсайхан, Л.Болд, Ж.Батзандан нар М.Энхболдод дахин албан бичиг хүргүүлж буй талаараа УИХ-ын даргын өрөөний үүдэнд мэдээлэл хийв. Тус бичигт "УИХ-ын дарга М.Энхболд таныг УИХ-ыг даргалах ёс зүйн эрхгүй гэж үзэж байгаа тул УИХ-ын тухай хуулийн 10.2.2-т заасны дагуу чөлөөлөгдөх хүсэлтээ гаргана уу. Уг хүсэлтээ гаргатал УИХ-ын гишүүд бид УИХ-ын чуулган болон байнгын хорооны хуралдаанд оролцох боломжгүй гэдгээ үүгээр уламжилж байна. Үүнээс үүсэж болох аливаа эрсдэл сөрөг үр дагаврыг та хариуцах болно гэдгийг мэдэгдье" гэжээ.

Тэмцлийн хурц хэлбэрийг сонгохоо илэрхийлж байсан гишүүдийн Төрийн ордон дахь тэмцэл энэ хүрээд үргэлжлэх боломжгүй болсныг Л.Оюун-Эрдэнэ хэлсэн. Мөн албан бичигт гарын үсэг зурсан гишүүдийн төлөөлөл УИХ-ын даргыг огцруулах асуудлаар ҮАБЗ-д хандаж буйгаа мэдэгдэж, өнөөдрөөс гудамжинд гарч иргэний нийгмийн болон ТББ-уудтай хамтарч эсэргүүцлээ жагсаал цуглаанаар үргэлжлүүлэх болсноо зарласан юм.

Ийн УИХ-ын 38 гишүүн чуулганы болон байнгын хорооны хуралдаанд оролцохгүйгээ мэдэгдсэн бол М.Энхболдыг чөлөөлөх шаардлагагүй гэж үзэж буй гишүүдийн дөрвөн нь Засгийн газрыг Үндсэн хууль зөрчсөн гэж үзэж Цэцэд хандсанаа мэдэгдэв. Гэхдээ Л.Энх-Амгалан, Д.Оюунхорол, Д.Ганболд, С.Бямбацогт нар УИХ-ын гишүүнийхээ хувиар бус иргэнийхээ эрхийн дагуу ҮХЦ-д хандаж буй юм.

Л.Энх-Амгалан хэлэхдээ "Нэр бүхий дөрвөн иргэн Засгийн газар УИХ-ын өмнө хүлээсэн үүргээ биелүүлэхгүй Үндсэн хуулийн тодорхой заалтууд зөрчсөн гэж үзэж байгаа. Тухайлбал "Хууль дээдлэх нь төрийн үндсэн зарчим мөн" гэсэн Үндсэн хуулийн үндсэн зарчмыг зөрчиж байна. Үндсэн хууль болон бусад хууль тогтоомжийг хэрэгжүүлэх үүргийг УИХ-ын өмнө хүлээсэн Засгийн газар хууль дээдлэх зарчмаас ухарч байгаа нь байж болохгүй явдал. Тус хуулийн 41.1-д "Монгол Улсын Ерөнхий сайд Засгийн газрыг удирдаж, төрийн хууль биелүүлэх ажлыг УИХ-ын өмнө хариуцна", 41.2-т "Засгийн газар үйл ажиллагаагаа УИХ-д тайлагнана" гэж заасныг тус тус зөрчсөн. Мөн Ерөнхий сайд, сайд нар парламентад Засгийн газраас өргөн барьсан асуудлыг хариуцах үүргээ биелүүлэхгүй УИХ-ын тухай хуулийн 29.6 болон УИХ-ын дэгийн тухай хуулийг зөрчсөн. Түүнчлэн Засгийн газрын тухай хуулийн 24.5 дахь заалтыг өөрсдөө зөрчсөн гэж үзэж байгаа. Бас "давхар дээл"-тэй сайд нар УИХ-ын гишүүнийхээ үүргийг умартаж УИХ-ын дэгийн тухай хуулийн "УИХ-ын гишүүн хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр чуулган болон байнгын хорооны хурлыг орхихгүй, товлосон цагт хүрэлцэн ирэх үүрэгтэй" гэсэн заалтыг зөрчиж байна. Тиймээс бид Засгийн газрын гишүүдийн дээрх хууль зөрчсөн үндэслэлүүдийг хянан тогтоож өгөхийг ҮХЦ-ээс хүссэн" гэв. [ЗГМ]

ЭРХ ЗҮЙ

УБЕГ, ШШГЕГ нь Засгийн газрыг хууль зөрчсөн нөхцөл рүү түлхэж байна

Дээд шүүхийн тогтоолыг хэрэгжүүлэхийн төлөө туушттай ажиллана

◀1

Монгол Улсын Үндсэн хууль болон Захиргааны ерөнхий хууль, Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд зааснаар улсын Дээд шүүх аливаа маргааныг эцэслэн шийдвэрлэмэгц иргэн, хуулийн этгээд, төрийн захиргааны байгууллага хэн боловч дээд шүүхийн шийдвэрийг эцэслэн биелүүлэх үүрэгтэй.

Гэвч шүүхийн тогтоол биелэгдэхгүй байгаа учир манай компани шүүхэд хүсэлт тавьж, уг шийдвэрийг албадан биелүүлэх хүсэлт гаргасан. Энэ дагуу шүүхээс 2018 оны арваннэгдүгээр сарын 16-ны өдөр Улсын дээд шүүхийн тогтоолыг албадан гүйцэтгэх захирамж гарсан юм. Улмаар 2018 оны арваннэгдүгээр сарын 30-ны дотор сайн дураар биелүүлэх захирамжийг Улсын бүртгэлийн ерөнхий газар (УБЕГ), Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт (ТӨБЗГ) өгсөн. Гэвч энэ хугацаанд шүүхийн шийдвэрийг биелүүлээгүй. Мөн сайн дураар биелүүлэхийг заасан хугацаа буюу өнгөрсөн арваннэгдүгээр сарын 30-наас хойш одоо 15 гаруй хоног өнгөрөөд буй ч шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагууд шийдвэр гүйцэтгэх ажиллагааг явуулалгүй, ямар ч ажиллагаа хийхгүй хууль зөрчиж байна. Өөрөөр хэлбэл, шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага албан тушаал эрх мэдлээ хэтрүүлж, бусдад буюу УБЕГ, ТӨБЗГ-т давуу байдал бий болгож байна гэж үзэх үндэслэл бий.

-Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага бусдад давуу байдал бий болгох нь өөрөө гэмт хэргийн шинжтэй үйлдэл. Энэ тухайд таны байр суурь ямар байна вэ?

-Давуу байдал бий болгох нь Эрүүгийн хуулийн 22.1-д заасан гэмт хэргийн шинжтэй үйлдэл. Ялангуяа, төрийн захиргааны албан тушаалтан буюу шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага шүүхийн тогтоол биелүүлэхгүй байгаа нь гэмт хэргийн шинж агуулж буй. Тиймээс манай компани Авлигатай тэмцэх газарт (АТГ) гомдол гаргасан. Энэ дагуу тус газраас холбогдох ажиллагааг хэрэгжүүлж, шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын холбогдох албан тушаалтнуудыг шалгаж эхэлсэн. УБЕГ ч шүүхийн шийдвэр биелүүлээгүй тул мөн АТГ-т гомдол гаргасан. УБЕГ-ын дарга нь Улсын ерөнхий бүртгэгч гэдэг утгаараа хуулийн хариуцлага хүлээх учиртай. Шийдвэр гүйцэтгэгчид, түүний удирдлага мөн адил.

Түүнчлэн шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага, УБЕГ нь Хууль зүй, дотоод хэргийн яамны харьяа агентлаг болохыг бид мэднэ. Өөрөөр хэлбэл, тус яамнаас ерөнхий удирдлагаар хангадаг гэсэн үг. Гэхдээ Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль болон Улсын бүртгэлийн тухай хуульд зааснаар үндсэн чиг үүргийн асуудлаа эдгээр байгууллага хуулийн дагуу биелүүлэх үүрэгтэй.

Харамсалтай нь, дээд шатны удирдлагаас хууль бусаар нөлөөлж, манай компанитай холбоотой шийдвэр биелэгдэхгүй, шийдвэр гүйцэтгэгч нар нь ажлаа хийхгүй, манай компанийн төлөөллийг хүлээн авч уулзахгүй байдал үүсчихээд байна. Тийм учраас дээд шатны удирдага буюу харьяа яамнаас Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газар (ШШГЕГ), УБЕГ-т нөлөөлж байж болзошгүй гэж үзэн, Авлигатай тэмцэх газарт гомдол гаргаад байгаа. Хэрвээ нөлөөлсөн нь тогтоогдвол холбогдох албан тушаалтнууд болон манай компанийн эрх ашгийг зөрчиж буй ШШГЕГ болон УБЕГ-ын эрх бүхий албан тушаалтнууд хуулийн хариуцлага хүлээх үндэслэл бүрдэнэ.

> **Шүүхийн тогтоол биелэгдэхгүй байгаа учраас манай компани шүүхэд хандсан**

Холбогдох хуульд зааснаар шүүхийн тогтоолыг хүлээн авснаас хойш гурав хоногийн дотор шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагаас мэдэгдэл хүргүүлэх ёстой. Гэтэл энэ оны арваннэгдүгээр сарын 30-наас албадан гүйцэтгэх ажиллагаа эхлэх ёстой байтал шүүхийн шийдвэр гүйцэтгэх газраас ямар ч бичиг гаргаагүй байгаа юм.

С.Батсайхан / ЗГМ©

-Энэ хэрээр цаг хугацаа алдана. Ялангуяа, бизнесийн байгууллагын хувьд оны эцэс нь тайлан тооцоогоо нэгтгэж дүгнэх, ирэх оны төлөвлөгөөгөө боловсруулах үе. Гэтэл энэ чухал үед шүүхийн шийдвэрийн гүйцэтгэл удааширч буй нь бизнесийн үйл ажиллагаанд нөлөөлж байна уу?

-Мэдээж хэрэг. Тухайлбал, "Эрдэнэт үйлдвэр"-ийн ТУЗ энэ оны нэгдүгээр сард хуралдсанаас хойш албан ёсоор нэг ч удаа хурал хийгээгүй. Тиймээс энэ оны эхээр баталсан компанийн дүрэм журам, үйл ажиллагааны тайланг хэлэлцэх, шинэ оны төлөвлөгөөг батлах хугацаа тулчихаад байгаа. Энэ мэт "Эрдэнэт үйлдвэр"-ийн эрх ашиг, мөн үйлдвэрийн ажилчидтай холбоотой олон асуудал хүлээгдээд байна. "Эрдэнэт үйлдвэр"-ийн ТУЗ-ийн гишүүдийн зүгээс шүүхийн шийдвэр биелсэн нөхцөлд хуралдаж, холбогдох асуудлаа хэлэлцэнэ гэсэн нэгдсэн байр суурьтай байгаа. Гэвч холбогдох байгууллагууд нь ийн илт хууль зөрчсөн үйлдэл хийсээр байна.

-Ер нь шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага шүүхийн тогтоолыг үг дуугүй биелүүлэх үүрэгтэй газар. Ингэж удаашруулж, гацаах нь ямар эрсдэл дагуулах бол?

-Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын үндсэн бөгөөд цорын ганц үүрэг нь шүүхийн шийдвэрийг гүйцэтгэх. Гэтэл Улсын дээд шүүхийн хүчин төгөлдөр тогтоол гарчихаад байхад нэг ч үйлдэл хийхгүй байна. Ялангуяа, албадан гүйцэтгэх захирамж гараад сар орчмын хугацаа өнгөрөөд байна.

Шийдвэр гүйцэтгэх байгууллагын нэр бүхий удирдлагууд дээд шатны байгууллагаас хууль бусаар үүрэг даалгавар авсан байж болзошгүй гэсэн мэдээлэл бий. Тодруулбал, "Монголын зэс" корпорацитай холбоотой улсын бүртгэлийг гацаах даалгавар өгсөн гэх мэдээлэл бидэнд ирсэн. Бид энэ талаар АТГ-т хандсан. Хэрэв эрх бүхий албан тушаалтан хууль зөрчсөн бол эрүүгийн хариуцлага хүлээнэ.

Түүнчлэн УБЕГ ч ялгаагүй бүртгэх үүрэгтэй. Гэтэл Улсын дээд шүүхийн тогтоол гарчихаад байхад тус байгууллагаас үүнд тайлбар хэлэх хууль зүйн ямар ч үндэслэл байхгүй. Эцэст нь хэлэхэд, эдгээр байгууллагын хууль бус үйлдэл нь эргээд Засгийн газрыг хууль зөрчсөн нөхцөл байдал руу түлхэж байна. Манай компани Дээд шүүхийн тогтоолыг хэрэгжүүлэхийн төлөө шат шатны байгууллагуудад хандан, тууштай ажиллана. Эрх бүхий байгууллагуудад хуулийн дагуу шийдэх хүсэлт тавьсаар байх болно. [ЗГМ]

Цаг үе

Дуудлага өгснөөс хойш дөрвөн цагийн турш үзлэг хийж, 21.10 цагт цогцсыг зөөвөрлөн авч явлаа.

С.Батсайхан / ЗГМ©

АНУ-ын зэвсэгт хүчний хошууч нас барсан байдалтай олдлоо

ЭСЯ-ныхан Батлан хамгаалах яамтай хамтран бүх асуудлыг шийдвэрлэхээ мэдэгдэв

Э.Батцэцэг
ЗГМ

ШШҮХ-ийн автомашинд цогцсыг зөөвөрлөхөөр бэлтгэж байна.

С.Батсайхан / ЗГМ©

17.45 цагт ШШҮХ-ийн өөр нэг автомашин ирлээ.

Б.Хасуй / ЗГМ©

Монгол Улсын Батлан хамгаалах яам болон АНУ-ын Төрийн Департаментын хамтын ажиллагааны хүрээнд хүрэлцэн ирсэн АНУ-ын иргэн, зэвсэгт хүчний хошууч, 34 настай эрэгтэй М.К.Стьюарт "Шангри-Ла" зочид буудалд буудалласан өрөөндөө уржигдар орой нас нөгчсөн ноцтой хэрэг гарлаа. Одоогоор хэргийн газраас олдсон байдлаар гадны нөлөөгүй, амиа хорлосон байж болзошгүй гэж үзэж байгаа ч шинжилгээний эцсийн дүгнэлт гартал түүнийг өөрийгөө егүүтгэсэн, эсвэл хорлогдсон эсэх мэдээлэл тодорхойгүй байна.

Зочид буудлын үйлчилгээний ажилтан цэвэрлэгээ хийх үедээ түүнийг анх олжээ. Өрөөнд нь ормогц АНУ-ын зэвсэгт хүчний офицер шкафны төмрөөс бүсээрээ хоолойгоо боож, амьсгал хураасан байхыг харсан тэрбээр цагдаагийн байгууллагад дуудлага өгчээ. Алба хаагчид болон элчингийнхэн маш түргэн хэргийн газарт ирсэн байна. Гэвч үзлэг хийхээр очсон шүүх шинжилгээнийхэн болон цагдаа нарыг Элчин сайдын яамныхан дотогш нэвтрүүлэхгүй цаг орчим шалтгаангүйгээр саатуулсан бөгөөд эцэст нь ойлголцолд хүрч, АНУ-ын Элчин сайдын яамныхантай хамт цагдаа, шинжээчид үзлэг хийж гүйцэтгэжээ.

"АНУ-ЫН ЗЭВСЭГТ ХҮЧНИЙ ОФИЦЕР МОНГОЛ УЛСАД НАС НӨГЧСӨН ЯВДАЛД ТӨРИЙН ДЕПАРТАМЕНТ ГҮНЭЭ ХАРАМСАЖ БАЙНА"

Ингээд бид Монгол дахь АНУ-ын ЭСЯ-наас энэ хэргийн талаар тодруулга хүссэн юм. Тэдний зүгээс "АНУ-ын зэвсэгт хүчний офицер Монгол Улсад нас нөгчсөн явдалд Төрийн Департамент гүнээ харамсаж байна.

Бид түүний гэр бүлийнхэн болон ойр дотныхонд нь гүн эмгэнэл илэрхийлье. АНУ-ын Төрийн Департамент болон Батлан хамгаалах яам Монгол Улсын холбогдох байгууллагуудтай хамтран энэхүү харамсалтай үйл явдлыг тойрсон бүх асуудлыг зөв зохистой бөгөөд хүндэтгэлтэй байдлаар шийдвэрлэхээр ажиллаж байна. Тусламж дэмжлэг үзүүлж буй Монгол Улсын Засгийн газарт бид талархаж байна. Гэр бүлийнхнийг нь хүндэтгэх үүднээс бид үүнээс өөр мэдээлэл өгөх боломжгүй байна" хэмээн хэвлэлийн төлөөлөгчөөрөө дамжуулан мэдэгдлээ. Цаашид хэргийн явцын талаар мэдээлэл солилцож, хамтран ажиллах тул цахим хуудсуудаар яваа албан бус мэдээлэлд автахгүй байхыг хүссэн юм.

Түүнчлэн уг хэргийн талаар ЦЕГ-ын Хэвлэл мэдээллийн төвөөс тодруулахад "Ийм хэрэг гарсан нь үнэн. СБД-ийн Цагдаагийн нэгдүгээр хэлтэст хэрэг бүртгэлт үүсгэсэн. Шалгах ажиллагаа дөнгөж эхэлж байгаа учраас дэлгэрэнгүй мэдээлэл өгөх боломжгүй" гэв.

Харин Батлан хамгаалахын сайд Н.Энхболдтой утсаар холбогдох гэсэн боловч "одоогоор ярих боломжгүй байна" гэсэн хариу өгчихөөд, дахин ямар ч дуудлага авсангүй. Гадаад харилцааны сайд Д.Цогтбаатар Ерөнхий сайдын айлчлалаар Япон улсад яваа. Тиймээс тус яамны Олон нийттэй харилцах албаны даргаар саяхан томилогдсон н.Төмөрбаатартай хэдэнтээ холбогдох гэсэн боловч утсаа бас л авсангүй. [ЗГМ]

- **АНУ-ын ЭСЯ-ныхантай хамт цагдаа, шинжээчид үзлэг хийж гүйцэтгэжээ.**
- **Хамгаалалтын албаныхан жирийн иргэдийг хөөж туун, үйлчлүүлэгчдийг байцаах зэргээр таагүй байдал үүсгэсээр байв.**
- **Хэргийн талаар ЦЕГ-аас тодруулахад "Ийм хэрэг гарсан нь үнэн. Шалгах ажиллагаа дөнгөж эхэлж байгаа учраас дэлгэрэнгүй мэдээлэл өгөх боломжгүй" гэв.**

Цогцсыг гаргах үеийн зураг авсан сэтгүүлчийг зочид буудлын хамгаалалтынхан саатуулж, сүрдүүлэв

Манай сонины сурвалжлах баг уг хэргийг сурвалжлахаар "Шангри-Ла" зочид буудалд 17.30-21.30 цагийн хооронд отолт хийсэн юм. Энэ үеэр зочид буудлын гадаа "ДК" серийн дугаартай АНУ-ын ЭСЯ-ны автомашинууд, мөн төрийн тусгай хамгаалалтын хар теньтэй хэд хэдэн автомашин ирж, буцаж, албаны хүмүүс хөл хөдөлгөөн ихтэй байлаа.

Түүнчлэн тус зочид буудлын хамгаалалтын албаныхан гадна орчныг "цэвэрлэж" жирийн иргэдийг хөөж туун, үйлчлүүлэгчдийг байцааж, бүр орох газар руу нь дагуулан явж хүргэх зэргээр таагүй байдал үүсгэсээр байв.

Нарийн учрыг мэдээгүй үйлчлүүлэгчид "Шангри-Ла"-гийн ажилчдын бүдүүлэг шаардлагад дургүйцэж байгаа нь илт байлаа.

Манай сурвалжлах баг хөөгдөж туугдан, нуугдаж дальдчин дөрвөн цагийн турш хүлээсний эцэст 21:10 цаг орчимд хохирогчийн цогцсыг шүүх шинжилгээний автомашинд зөөвөрлөх үеийн зургийг авсан юм. Гэвч тус буудлын хамгаалалтынхан манай гэрэл зурагчны араас хөөж баривчлан, зургийн аппаратыг нь булааж, гарыг нь мушгин буудал руугаа чирж оруулсан юм.

Түүгээр ч зогсохгүй ажил үүргээ гүйцэтгэж яваа сэтгүүлчийн биед халдан нэгжлэг хийж, утаснуудынх нь дуудлага, мессежийг шалган, авсан зургуудыг маань шууд устгаж зүй бусаар авирласан. Улмаар "Цагдаагийн байгууллагад өгч саатуулна" хэмээн тусгай өрөөнд хорихыг завдан, эрхээ хэтрүүлэн хууль зөрчсөөр байв.

Өөрийгөө егүүтгэсэн үү, хорлогдсон уу гэдэг нь тодорхойгүй байна

Харин цагдаагийн алба хаагчид манай зурагчны үйл явдлын зураг дарахыг мэдсэн ч хорьж саатуулах хуульгүй учраас орхиод явцгаасан юм. Сэтгүүлч мэдээлэх үүргийнхээ дагуу ажил үүргээ гүйцэтгэх явцад хувийн нэг байгууллагын хамгаалалтын алба бүү хэл хуулийн байгууллага, төрийн албаныхан саатуулах ёсгүй. Монгол Улс нэгдэн орсон олон улсын конвенцид сэтгүүлчийн мэдээлэл олж авах эрхийн халдашгүй байдлыг тунхагласныг хуулийг гууль болгодог хамгаалалтын "булчингууд" яаж ч ойлгох билээ. Гэрээт хамгаалалтын албаны тухай хуулийн 5.3-т "...харуул хамгаалалт эрхлэх хуулийн этгээд иргэдийн амь нас, эрүүл мэнд, хүрээлэн буй орчинд гэм хор учруулахгүйгээр үүргээ гүйцэтгэх ёстой" гэж заасан байдгийг үүгээр тэдэнд дайя. Мөн техник технологи хөгжсөн өнөө үед устгасан зургийг амархан сэргээдэг болсныг сануулж, хүч түрэмгийлсэн бүдүүлэг аргаар буудлынхаа нэр хүндийг аврахыг хичээсэн оролдлогыг чинь нураасандаа хүлцэл өчье.

Энэ хэргийн талаар бид үргэлжлүүлэн мэдээлэх болно. [ЗГМ]

Би үйлдвэрлэгч

Б.Ану-Үжин: Үнэртэй усны суурь үнэр хамгийн чухал

С.Батсайхан / ЗГМ©

Зөвхөн өөрийнхөө таалсан үнэрийг зохион бүтээчихэж болохгүй. Хүн бүрийн сонирхол өөр шүү дээ.

Бизнест хожимдоно гэсэн ойлголт байдаггүй

Г.Санжааханд
ЗГМ

Yours truly by UJIN. Энэ бол монгол эмэгтэйн зохион бүтээсэн үнэртэй усны брэнд нэр. Оюутан ахуйдаа өөрийн брэндийн үнэртэй ус бүтээх санаагаа олсон Б.Ану-Үжин Америкт мэргэжил дээшлүүлж байх хугацаандаа анхны бүтээгдэхүүнээ гаргаж авчээ. Ингээд Yours truly by UJIN брэндийн талаар үүсгэн байгуулагч Б.Ану-Үжинтэй ярилцлаа.

-Үнэртэй ус хийх санаа хэрхэн төрсөн бэ?

-Оюутан байхдаа импортыг орлох ямар нэгэн бүтээгдэхүүн эх орондоо үйлдвэрлэх юмсан гэж боддог байлаа. Спортын хувцаснаас эхлээд Монголдоо үйлдвэрлэж болох бүх л зүйлийг судалж, сонирхсон. Олон жил судалсны эцэст үнэртэй ус хийх санаа төрсөн юм. Тухайн үед Монголд үнэртэй ус ид дэлгэрч байв. Би өөрийгөө хожимдчихсон байх гэж бодсон ч судалгаагаа үргэлжлүүлсэн. Шинэ бизнест хожимдоно гэсэн ойлголт байдаггүй юм байна. Судалгаагаа онлайнаар хийж, охид эмэгтэйчүүдийн саналыг авдаг байсан. Харин яг үнэртэй усаа зохиох ажлаа өнгөрсөн оны дөрөвдүгээр сараас эхэлсэн. Аравдугаар сард нь анхны бүтээгдэхүүнээ гар дээрээ авсан. Ингэж л 100 хувь байгалийн гаралтай, жимс болон цэцгийн үнэртэй, дэлхийн жишигт нийцүүлэн Америкт үйлдвэрлэсэн үнэртэй усыг Монгол Улсад худалдаанд гаргахад бэлэн болсон доо. Бүтээгдэхүүн хөгжүүлэлтээ өнөөдрийг хүртэл хийсээр л байна

-Үнэртэй усаа Америкт хийдэг гэсэн үг үү?

-Би уг нь мэргэжил дээшлүүлэхийн тулд Америк явж сурсан. Миний мэргэжлийн үндсэн чиглэл нь үйлдвэрлэлтэй холбоотой. Монголд заалгасан бүх хичээлээ Америкт магистрын түвшинд үзсэн учир илүү их сэдэл өгсөн. Сурч байх явцад үнэртэй ус хийх боломж гарсан тул үзээд алдъя гэж бодсон юм. Монгол эмэгтэй үнэртэй ус хийсэн гэхээр хүмүүст их хол сонсогдох байх. Гэхдээ америк стандартаар бүтээсэн гэхээр өөрөөр хүлээж авдаг.

-Үнэртэй ус хийх технологийг хэрхэн эзэмшсэн бэ?

-Би анх үнэртэй усыг хэрхэн боловсруулах, яаж хийх талаарх сургалтад суусан. Тиймээс анх машины үнэртүүлэгч, тасалгааны үнэртүүлэгч зэрэг жижиг зүйл хийдэг байсан. Харин эцэст нь үнэртэй усаа гаргаж аваад, Америк руу үйлдвэрт илгээсэн. Тус улсад үнэртэй уснаас бүтээгдэхүүний аюулгүй байдлын агентлаг болон хоол, хүнс, эмзүйн хяналтын газар бүх шинжилгээг авдаг. Хүний биед аюулгүй, чанарын шаардлага хангасан эсэхийг шалгана гэсэн үг.

-Бүтээгдэхүүнээ Америкт худалдаалж байгаа гэсэн. Зах зээлийн судалгаа хийсэн үү?

-Америкийн зах зээлд өнгөрсөн сарын 27-ноос худалдаанд гарлаа. Одоогийн байдлаар Америкт амьдардаг монголчууд их сонирхож байгаа. Монгол хүн үйлдвэрлэсэн гэхээр бүр их сонирхож байх шиг.

-Харин Монголдоо хэрхэн борлуулж байна вэ. Зах зээлийн үнэ нь хэд байгаа вэ?

-Энэ сарын 10-наас хэрэглэгчдэдээ хүрч эхэлсэн. Одоогоор онлайнаар захиалга авч, хүргэж өгч байна. Цаашид томоохон дэлгүүрүүдээр худалдаална. Бүтээгдэхүүнээ 77900 төгрөгөөр борлуулахаар болсон.

-Үнэртэй усныхаа нэрний талаар ярихгүй юу. Yours truly by UJIN гэж нэрлэх болсон шалтгаан юу вэ?

-Yours truly by UJIN гэдэг нь Үжингээс танд гэсэн утгатай. Монголчууд Үжин гэдгийг зүгээр нэг энгийн нэр гэхээс илүү хатан гэдэг утгыг агуулж ойлгодог шүү дээ. Тиймээс хатангаас танд гэсэн утгыг илэрхийлж байгаа гэж ойлгож болно. Миний хамгийн анхны брэнд Yours truly гээд үнэртэй ус байсан. Зөвхөн танд монгол хатнаас гэсэн нэртэй. Perfume by UJIN гэдэг бол миний байгуулах компанийн нэр.

- **Монгол эмэгтэй үнэртэй ус хийсэн гэхээр хүмүүст их хол сонсогдох байх. Гэхдээ америк стандартаар бүтээсэн гэхээр өөрөөр хүлээж авдаг.**
- **Зөвхөн үнэртэй ус хийхгүй. Цаашдаа биеийн шингэн саван гэх мэт гоо сайхны бүтээгдэхүүн зохион бүтээнэ гэж боддог.**
- **Манай бүтээгдэхүүн үнэрээ 7-8 цаг барьдаг.**

-Өөрийн гэсэн компаниа хэзээ байгуулах вэ?

-Ойрын нэг жилийн хугацаанд өөрийн гэсэн компанитай болно гэж төлөвлөсөн. Яагаад гэвэл дараагийнхаа хийх бүтээгдэхүүний санааг олсон. Тэр бүтээгдэхүүнээ Монголдоо үйлдвэрлэхийг зорьж байна.

-Цаашдын зорилгынхоо талаар ярихгүй юу?

-Зөвхөн үнэртэй ус хийхгүй. Цаашдаа биеийн шингэн саван гэх мэт гоо сайхны бүтээгдэхүүн зохион бүтээнэ гэж боддог. Эдгээр бүтээгдэхүүнийг хийхэд шаардлагатай тоног төхөөрөмжүүдийг Монголдоо оруулж ирж байгаа.

-Манай улсад үнэртэй усны олон алдартай брэнд орж ирдэг. Эдгээр брэндүүдтэй хэрхэн өрсөлдөх вэ?

-Маркетингийн төлөвлөгөө бол бий. Одоохондоо дөнгөж бүтээгдэхүүнээ таниулж байна. Цаашдаа үйлдвэрлэл маань тэлж, бүтээгдэхүүний нэр төрөл ч өргөжөөд явна. Тэгэхээр шат шатны дамжлагаар маркетингаа хийх юм. Одоохондоо зах зээлээ мэдрэх, Монголд хэрэглэгчдээ тандах, үнэртэй усны зах зээл өөрөө ямар байна гэх мэт судлах зүйл их бий. Манайд үнэртэй ус үйлдвэрлэдэггүй болохоор тоног төхөөрөмж болон түүхий эд гээд бүхнийг гаднаас оруулж ирнэ.

-Үнэртэй ус хийхэд ямар бэрхшээл тулгарч байв?

-Хамгийн хэцүү нь үнэр. Үнэртэй ус гурван үнэрээс бүрддэг. Бүгд өөр өөр үнэртэй. Үнэртэй усыг түрхэхэд хамгийн түрүүнд үнэртэж байгаа нь толгойн үнэр, 15-30 минутын дараа дунд үнэр нь үнэртэнэ. Харин нэг цагийн дараа танд үнэртэж байгаа үнэр нь суурь үнэр юм. Суурь үнэрээ хэр сайн гаргаж чадна, тэр үнэр удаан тогтоно гэсэн үг. Энэ үнэр гоё санагдсан тохиолдолд хэрэглэгчдэд таалагддаг. Хүмүүс хурц, нялуун, зөөлөн зэрэг янз бүрийн үнэрт дурладаг. Манай бүтээгдэхүүн үнэрээ 7-8 цаг барьдаг.

Тиймээс хэрэглэгчдээ мэдрэх хэрэгтэй. Зөвхөн өөрийнхөө таалсан үнэрийг зохион бүтээчихэж болохгүй. Хүн бүрийн сонирхол өөр шүү дээ. [ЗГМ]

[ЗГМ СОНИН]

"Засгийн газрын мэдээ" сонин нь ардчилсан, шударга ёс, хүний эрхийг дээдэлж, чөлөөт сэтгүүл зүйн хэм хэмжээг бүрнээ сахин, олон ургальч үзлийг илэрхийлэх мэдээллийн индэр байж, нийт Монгол үндэстний ойлголцол, эв нэгдлийг бэхжүүлэхийг эрхэм зорилгоо болгоно.

ТУЗ-ийн дарга
Эрдэнэбаатарын ДОЛГИОН

Ерөнхий эрхлэгч
Баатарын ДУЛАМХОРЛОО

Зөвлөх
Шатарбалын ДАВААДОРЖ

Орлогч эрхлэгч
Лхагважавын СУГАРМАА
Утас: 99903584

РЕДАКЦ

Улс төр, нийгэм, эрэн сурвалжлах мэдээллийн алба
Эдитор Б.Энхжаргал
Утас: 99901621

Цахим контент, бүтээлч үйлдвэрлэлийн алба
Эдитор Г.Баярсайхан
Утас: 99903574

Эдийн засаг, уул уурхайн мэдээллийн алба
Эдитор З.Цэлмэг
Утас: 99901526

ЗАР СУРТАЛЧИЛГАА

Утас: 99903581
99903578
99907843

ХАЯГ

Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг,
I хороо, Энхтайваны өргөн чөлөө,
"Блю Скай тауэр" 407 тоот
Улсын бүртгэлийн дугаар. 1024
Утас: 70103131,
Факс: 7010606

ЦАХИМ ХУВИЛБАР

zgm.mn
ubinfo.mn
Дугаарын удирдагч
Г.Баярсайхан

8 658000 029112 001042



Сурталчилгаа

С.Энх-Ирээдүй: ХААН Банкинд хаалттай цаг байхаа болилоо

Банк санхүүгийн салбарт техник технологийн хөгжил дэвшил хэрхэн нөлөөлж буйг бид өдөр тутамдаа харж, мэдэрч, үр шимийг нь хүртэж байна. Банк гэсэн ойлголт барилга байшин төдийхнөөр төсөөлөгдөхөө хэдийнэ больж, иргэдийн дунд бэлэн мөнгөний оронд картын хэрэглээ нэвтэрч, тэр ч байтугай гар утастай л байхад банк санхүүгийн бүх хэрэгцээгээ хангах боломжтой болсон. Монгол орон даяар хамгийн өргөн цахим сүлжээтэй ХААН Банк харилцагчдынхаа цаг завыг хэмнэсэн ухаалаг бүтээгдэхүүн үйлчилгээг цаг үргэлж санал болгосоор ирсэн бөгөөд энэ удаа цоо шинэ төхөөрөмж туршилтаар нэвтрүүлээд буй нь өөртөө үйлчлэх банк буюу Киоскийн машин юм. Харагдах байдлаараа АТМ-тай төстэй болович маш олон "ид шид"-тэй, иргэдийн цаг завыг хэмнэсэн энэхүү ухаалаг автомат машины талаар дэлгэрэнгүй мэдээлэл авахаар ХААН Банкны Цахим банк, АТМ-ын сувгийн газрын захирал С.Энх-Ирээдүйтэй ярилцлаа.



-Юуны өмнө энэ том төслийн ард гарч, Монголын банкны салбарт цоо шинэ технологи нэвтрүүлсэн танай хамт олонд баяр хүргэе. Киоск машины гол давуу тал, онцлог юу вэ?

-Баярлалаа. Аливаа харилцагчид хоёр төрлийн санхүүгийн хэрэгцээ байдаг. Бэлэн болон бэлэн бус гүйлгээ, нөгөөх нь санхүүгийн бус үйлчилгээ юм. Киоскийн төхөөрөмжийн давуу тал нь Монголдоо анх удаа харилцагчид маань санхүүгийн бус хэрэгцээ буюу банкнаас авах шаардлагатай тодорхойлолтууд, дансны хуулга, зээлтэй эсэх лавлагаа зэргийг хэвлэн авах боломжтой боллоо. Мобайл банк, интернэт банк зэрэг бүх төрлийн үйлчилгээнд бүртгүүлэхээс гадна өдрийн аль ч цагт Монгол Улс дотор хүссэн банк руугаа бэлэн бусаар гүйлгээ хийх боломжтой. Яваандаа бид олон улсын гүйлгээ хийх боломжийг бүрдүүлэхээр хичээж байна. Хамгийн гол онцлог нь видеогоор онлайн туслахтай шууд холбогдож заавар зөвлөгөө авах боломжтой харилцуурыг энэ төхөөрөмжинд суурилуулж өгсөн. Харилцагчид маань Киоск машины камер, харилцуурын тусламжтайгаар яг теллертэй нүүр тулаад ярьж байгаа юм шиг дуу, дүрсний өндөр нягтаршилтайгаар шууд онлайн туслахтай харьцах боломжийг анх удаа нээж өгсөн. Энэ бүх үйлчилгээг цогцоор нь шийдсэнээрээ иргэд заавал банк явах шаардлагагүйгээр 24 цагийн аль ч үед санхүүгийн хэрэгцээгээ авах боломжтой боллоо. Өөрөөр хэлбэл, ХААН Банкинд хаалттай цаг гэж байхгүй болсон гэсэн үг. Энэ утгаараа жинхэнэ өөрөө өөртөө үйлчлэх банкны үйлчилгээний машин болж чадаж байна.

-Киоскоор үйлчлүүлэхэд ямар бичиг баримт шаардлагатай вэ?

-Тухайн хүн иргэний үнэмлэхээ уншуулаад, хурууны хээгээ таниулснаар үйлчилгээ авах боломжтой. Монгол Улсын хэмжээнд иргэнийг танин баталгаажуулах үйлдлийн хамгийн шалгарсан хувилбар нь тэр хүний хурууны хээ Дата төвд шалгагдаж, регистрийн дугаартай нь таарснаар тухайн хүн мөн эсэх нь баталгааждаг. Киоск машин яг л төрийн үйлчилгээний ТҮЦ машинтай ижил зарчмаар ажиллана. Монголчууд маань ТҮЦ машинаар үйлчлүүлээд сурчихсан тул харьцангуй хүндрэл бага гарах болов уу.

-Иргэний үнэмлэхээс гадна банкны картаа давхар уншуулах шаардлагатай юу?

-Шаардлагагүй, иргэний үнэмлэхээ уншуулж, хурууны хээгээр баталгаажуулж байгаа учраас карт хэрэггүй. Гүйлгээ хийхдээ код хийх ч шаардлагагүй. Гэхдээ зөвхөн бэлэн бус гүйлгээ хийх боломжтой. Харилцагчдын цаг зав, нэмэлт үйлдлийг хөнгөвчлөх нь л бидний гол зорилго юм.

-Ахмад настнууд болон технологиос хол байдаг зарим хүн АТМ-аар үйлчлүүлэхдээ түвэгшээдэг тал бий. Киоск машины онлайн туслахтай холбогдоод үйлчилгээгээ одоо саадгүй авах нь ээ?

-Тийм шүү. Орон нутгийн харилцагчид нийслэлийнхнийг бодвол технологиос харьцангуй хол байдаг. Хотын иргэд насны зааг хамаарахгүйгээр өдөр тутам АТМ ашиглаж байна шүү дээ. Эхний ээлжинд хүмүүст сонирхолтой л байх байх. Мэдээж технологиос хол байдаг хүмүүст дасахад хугацаа орно. АТМ-ыг анх нэвтрүүлж байхад хэрэглэж чаддаг хүн цөөхөн байсан. Экспресс банк ч ялгаагүй анх хүмүүс нэг л итгэж өгөхгүй, мөнгөө хийдэггүй байсан. Одоо иргэд хэнээс ч айхгүй тэр төхөөрөмжинд орлогоо хийж, бусад руу мөнгөө шилжүүлж чаддаг болсон шиг Киоск машиныг ч мөн ашигладаг болох байх. Ашиглахад аль болох хялбар болгох үүднээс бид 19 инчийн мэдрэгчтэй дэлгэц суурилуулж, мөн товчлууруудыг хүнд ойлгомжтой меню хэлбэрээр оруулсан. Товчлууруудын хэмжээ нь том учир настай хүн ашиглахад хялбар. Манай багийнхны хувьд тухайн хүн гар утас ашиглаж чаддаг л бол үүнийг ашиглах боломжтой гэсэн бодлого барьж ажилласан. Монголчуудын хувьд харьцангуй шинэ зүйлд дасан зохицох хурд, чадвар өндөртэй шүү дээ. Тэгэхээр технологи талаасаа Киоск машинаас хэрэгцээтэй үйлчилгээгээ авахад илүү амар, хялбар байх болов уу гэж тооцоолж байгаа.

-АТМ-ыг бодвол Киоск машинаар банк хооронд шууд гүйлгээ хийж болдгоороо давуу талтай санагдлаа?

-Тийм шүү. Нэгэнт иргэний үнэмлэхээ уншуулаад, хурууны хээгээ баталгаажуулж байгаа учраас ямар нэгэн лимитгүйгээр банк хооронд гүйлгээ хийх боломжтой. Энэ нь харилцагчдад таатай байх болов уу. Үүнээс гадна хүмүүс гүйлгээ хийсэн бол заавал тамгатай баримт авахыг хүсдэг. Өнөөдөр зайлшгүй байгаа нэг хэрэгцээ бол иргэдийг заавал биет салбараас биет цаас авчрахыг шаарддаг. Бусад байгууллагууд шаарддаг учраас харилцагчид заавал салбар тооцооны төвүүдэд ханддаг. Албан ёсны тамгатай тодорхойлолтыг Киоскоос хэвлэх боломжтой болж байгаа тул харилцагчид заавал банкнаас энэ үйлчилгээг очиж авах шаардлагагүй болсон. Гэхдээ бас сонголттой. Киоск маань зөвхөн тодорхойлолт хэвлэх биш, анх удаа манай банкнаас гаргаж байгаа албан ёсны баримтыг цахим суваг дээрээс хүссэн газар руу нь илгээх боломжтой. Өөрөөр хэлбэл, дансны хуулгаа та хэвлэж авалгүйгээр илгээх газрынхаа и-мэйл хаягийг оруулаад онлайнаар явуулж болно. Өөрийн и-мэйл хаягаа оруулаад авах ч бололцоотой. Энэ утгаараа цаасанд хэмнэлттэй.

-Одоогоор хэдэн киоск машин ашиглалтад оруулаад байна вэ?

-ХААН Банк цамхагийн 1-р давхарт байрлах Төв тооцооны төвд хоёр Киоск машин суурилуулж, 11-р сарын 30-наас ашиглалтад оруулсан. Энэ ондоо багтаад Ард төвлөрсөн тооцооны төв, Баруун хүрээ, Үйлдвэр комбинат байршилд нийтдээ 10 Киоскийн машин байршуулахаар төлөвлөсөн. ХААН Банк цамхагт байгаа киоскийн хоёр төхөөрөмжийг ашиглалтанд оруулснаас хойш 14 хоногийн хугацаанд давтагдсан тоогоор 5332 хүн үйлчлүүлсэн

байна. Үүнээс 4894 нь данс, картын мэдээллээ лавласан, 1331 нь дансны тодорхойлолт, хуулга хэвлэж авсан, 175 нь бэлэн бус гүйлгээ хийсэн байна. Киоск суурилуулсан байршлын тухайд бид судалгаан дээр үндэслэж, дээрх тооцооны төвүүдийг сонгосон.

-Ирэх онд хэдийг нэмж тавих вэ. Орон нутагт бас байршуулах уу?

-Бид ирэх онд 100 орчим Киоскийн төхөөрөмжийг улсын хэмжээнд байршуулах төлөвлөгөөтэй байна. Банкны үйлчилгээ ойр байна гэдэг аль ч газар давуу чанар. Тиймээс бид харилцагчдаа аль болох цахимжуулахыг оролдож байна. Киоскны хувьд бас нэг давуу тал нь Монгол Улсын хаана ч сүлжээтэй газар бид аваачаад тавьчихна. Увс, Баян-Өлгий, Дорноговь хаана ч байсан ялгаагүй төв оффис дээр сууж байгаа онлайн туслахтайхолбогдох боломжийг бий болгож өгч байна. Өөрөөр хэлбэл үйлчилгээний стандартыг орон даяар жигд болгох боломжийг бүрдүүлнэ. Ер нь энэ ажил маань ашгийн бус зорилготой, банкны үйлчилгээг хүмүүст ойртуулах, цаг завыг нь хэмнэх хийж буй төсөл шүү дээ. Иргэдийн банкинд оочерлох хүлээлгийн дундаж хугацаа 14 минут гэсэн тоо байдаг. Теллерээс үйлчилгээ авахад нэмээд 3 минут зарцуулна. Тэгвэл энэ 17 минутыг бид Киоскийн тусламжтай 45 секунд л болгох гээд байгаа юм. Энэ бол маш их цагийг гэр бүлдээ, амьдралдаа зарцуулах боломж олгож байгаа хэрэг. Энэ төхөөрөмж маань Энэтхэг, Солонгос, Сингапур зэрэг технологи өндөр хөгжсөн орнуудад сүүлийн ганц хоёр жилийн хугацаанд хөгжиж байгаа шинэ технологи.

-Шинэ технологийн хувьд аюулгүй байдлыг нь хэрхэн хангах вэ гэдэг асуудал дагалддаг?

-Банкны биет салбаруудад тавигддаг бүхий л стандарт шаардлагыг бүрэн хангасан байгаа. Камер, сүлжээний стандарт, хамгаалалтын бусад програмууд зэрэг хамгаалалтын шийдлийг бүрэн хангасан. Мөн төрийн мэдээлэл солилцооны "ХУР" системд холбогдсоноор харилцагчийн хурууны хээг мэдээллийн сангаас шалгадаг. Энэ мэдээллийг бид бүртгэж авдаггүй, бас хадгалж үлддэггүй. Энэ нь харилцагчийн хувьд өөрийн мэдээллээ алдах вий гэх бүх эрсдэлээс хамгаалагдаж байгаа юм.

IKH GOBI ENERGY LLC

"Их Говь Энержи" ХХК нь экспортын баримжаатай Монголын анхны антрацит нүүрсний уурхайн төсөл.
Таныг дараах нээлттэй ажлын байранд урьж байна.

СОНГОН ШАЛГАРУУЛЖ АЖИЛД АВНА

Нээлтийн огноо: 2018-12-14
Хаалтын огноо: 2018-12-26 17:30

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ

1 сарын цалин: 30 сая хүртэл
Бусад урамшуулал

Үндсэн үүрэг хариуцлага
- Компанийн стратегийн төлөвлөлтийг хийх, бизнес төлөвлөгөөний зорилтуудыг тодорхойлж, хэрэгжилтийг хангах, үйл ажиллагааны гүйцэтгэлийг хянах, үнэлгээ хийх, ажил үүргийг нэгж хэлтсүүдэд хуваарилах, ажил үүргийн уялдааг зохицуулах
- Компанийн үйл ажиллагаа нь хууль тогтоомж, компанийн бодлого, дотоод журамд нийцэж буйг хянах, компанийн дотоод хяналтыг удирдан чиглүүлэх
- Компанийн худалдан авагчид, үйлчлүүлэгчид, хамтрагчидтай үр өгөөжтэй харилцаа, хамтын ажиллагааг тогтоох, тэдгээрийн өмнө компанийг төлөөлөх
- Санхүүгийн гүйцэтгэл, борлуулалт болон үйл ажиллагааны талаарх гүйцэтгэлийн мэдээг хянан үзэх, үйл ажиллагаа, ажил үүргийн гүйцэтгэлийн арга хэлбэр, дадал, хэв маягийг сайжруулах
- Худалдан авах үйл ажиллагааны төсөв, төлөвлөгөө болон холбогдох гол үзүүлэлтүүдийг боловсруулах, гүйцэтгэлийг хянах, баталгаажуулах
- Хүний нөөцийн бодлогыг удирдан чиглүүлэх, хэрэгжилтийг хянах

Тавигдах шаардлага
- Санхүү, бизнесийн удирдлага, инженер техникийн болон төслийн удирдлагын аль нэг чиглэлээр магистр болон түүнээс дээш зэрэгтэй байх
- Дээр дурьдсан үүрэг хариуцлагыг гүйцэтгэж байсан бодит туршлагатай байх
- Ижил төрлийн удирдах түвшинд 8-аас дээш жил ажилласан туршлагатай байх
- Уул уурхайн салбарт ажиллаж байсан туршлагатай байх
- Гүйцэтгэл сайтай хамт олон бүрдүүлэх, манлайлах ур чадвар дадал туршлагатай байх
- Ажил үүргээ оновчтой хуваарилах, богино хугацаанд суралцах чадвартай байх
- Мэргэжлийн өндөр ёс зүйтэй, харилцааны өндөр соёлтой
- Англи хэлний бичгийн болон ярианы өндөр чадвартай байх

ҮЙЛ АЖИЛЛАГАА ХАРИУЦСАН ЗАХИРАЛ

1 сарын цалин: 25 сая хүртэл
Бусад урамшуулал

Үндсэн үүрэг хариуцлага
- Компанийн богино хугацааны бизнесийн зорилтуудыг тодорхойлох, энэ чиглэлээр дээд удирдлагыг дэмжиж ажиллах
- Төлөвлөгөө болон санхүүгийн гүйцэтгэлийн гол үзүүлэлтүүдийг биелүүлэх зорилгоор өдөр тутмын үйл ажиллагааг удирдан зохион байгуулж чиглүүлэх, ажлын горим, ачааллыг тодорхойлох
- Олборлолт ба үйлдвэрлэлийн үйл ажиллагааны төлөвлөгөөг боловсруулах, явцыг хянах, богино болон дунд хугацааны зорилтуудыг дэвшүүлэх, холбогдох төсвийг боловсруулах, үйлдвэрлэлийн норм нормативуудыг тодорхойлох, зардлын хэмжээ болон борлуулалтын тоо хэмжээг тодорхойлох, хэрэгжилтийг хянах
- Хэлтэс нэгжүүдийн хамтын ажиллагааг зохион байгуулах, уялдуулах зэрэг асуудлыг шууд хариуцан ажиллах
- Компанийн өндөр гүйцэтгэлийг хангах зорилгоор гүйцэтгэлийн үзүүлэлт дээр тулгуурласан цалин хөлс, шагнал урамшууллын оновчтой бодлого боловсруулах

Тавигдах шаардлага
- Бизнесийн удирдлага буюу төслийн удирдлагын аль нэг чиглэлээр магистр болон түүнээс дээш зэрэгтэй байх
- Дээр дурьдсан үүрэг хариуцлагыг гүйцэтгэж байсан бодит туршлагатай байх
- Ижил төрлийн удирдах түвшинд 8-аас дээш жил ажилласан туршлагатай байх
- Уул уурхайн салбарт ажиллаж байсан туршлагатай байх
- Гүйцэтгэл сайтай хамт олон бүрдүүлэх, удирдан чиглүүлэх, сургах, дадлагажуулах ур чадвартай байх
- Ажил үүргээ оновчтой хуваарилах, богино хугацаанд суралцах чадвартай байх
- Мэргэжлийн өндөр ёс зүйтэй, харилцааны өндөр соёлтой байх
- Англи хэлний бичгийн болон ярианы өндөр чадвартай байх

САНХҮҮ ЭРХЭЛСЭН ЗАХИРАЛ

1 сарын цалин: 25 сая хүртэл
Бусад урамшуулал

Үндсэн үүрэг хариуцлага
- Компанийн санхүүгийн үйл ажиллагааг шууд удирдах ба стратегийн хөгжлийн зорилтуудыг хэрэгжүүлэхэд чиглэгдсэн үйл ажиллагааг олон улсын болон Монгол улсын санхүү бүртгэлийн менежментийн аргачлал, стандартад нийцүүлэн ажиллах
- Компанийн үйл ажиллагаанаас улбаалан гарч буй санхүүгийн эрэлт хэрэгцээнд нийцсэн санхүүгийн бодлого, стратеги боловсруулах, хэрэгжүүлэх, хяналт тавих
- Компанийн мөнгөн урсгал, санхүүгийн төлөвлөгөөний гүйцэтгэлийг хангах, дүн шинжилгээ хийх, мөнгөн урсгал ба эргэлтийн хөрөнгөнд хяналт тавих, удирдлагад санхүүгийн гүйцэтгэлийн болон эрсдэлийн тайлан мэдээ боловсруулж танилцуулах
- Компанийн зүгээс хийх аливаа хөрөнгө оруулалттай холбоотой асуудлаар шийдвэр гаргах явцад гол үүрэг гүйцэтгэж оролцох
- Компанийн санхүүтэй холбоотой асуудлуудаар гадны байгууллагуудтай харилцаа холбоо тогтоож ажиллах, тэдгээрийн өмнө компанийг төлөөлөх
- Компанийн бүх төрлийн гэрээнд хяналт тавьж, зөвлөх
- Төсвийн шинжилгээ, санхүүгийн тайлан болон санхүүгийн чиг хандлагын мэдээллээр цаг тухай бүрт удирдлагаа мэдээллээр хангаж ажиллах
- Мөнгөн урсгалын төсөөлөл болон түүнийг тайлагнах загвар, механизмыг шинэчлэн боловсруулж тодорхойлох

Тавигдах шаардлага
- Бизнесийн удирдлага, Санхүү, нягтлан бодох бүртгэлийн чиглэлээр бакалавр, магистр болон түүнээс дээш зэрэгтэй байх
- Өргөн цар хүрээтэй бизнесийн байгууллагад санхүү, төлөвлөлт, нягтлан бодох бүртгэлийн чиглэлээр удирдах түвшинд 8-аас дээш жил ажилласан туршлагатай байх
- Мэргэшсэн нягтлан бодогч болон татварын итгэмжлэгдсэн нягтлан бодогч бол давуу тал болно.
- Санхүүгийн богино, дунд болон урт хугацааны төсөв, төлөвлөлтийг боловсруулах, үр дүнтэй хэрэгжүүлэх, мөнгөн хөрөнгө болон нягтлан бодох бүртгэлийн удирдлагыг хэрэгжүүлэх, хяналт тавих ур чадвартай байх
- Англи хэлийг ажил мэргэжлийн хүрээнд болон бизнесийн албан харилцаанд сайн ашигладаг
- Харилцааны өндөр соёлтой, бүтээлч хандлагатай, мэргэжлийн өндөр ёс зүйтэй байх

ХҮНИЙ НӨӨЦ ХАРИУЦСАН ЗАХИРАЛ

1 сарын цалин: 20 сая хүртэл
Бусад урамшуулал

Үндсэн үүрэг хариуцлага
- Компанийн хүний нөөцийн менежментийг төлөвлөж, удирдан зохион байгуулах, шаардлага хангасан, чадварлаг боловсон хүчнээр хангах, ажилтнуудыг сургаж хөгжүүлэх ажлыг зохион байгуулах, ажлын гүйцэтгэлийн үнэлгээ ба цалин хөлсний зөв системийг бий болгох замаар ажилтнуудын сэтгэл хангалуун, тогтвор суурьшилтай ажиллах нөхцөлийг бүрдүүлснээр байгууллагынхаа хөгжлийг дэмжих
- Ажилтан ажилд авах бодлогыг боловсруулан холбогдох дүрэм журмыг гаргах, Ажилтан, ажилчдын ажил эрхлэлттэй холбоотой харилцааг зохицуулах бүхий л бодлого, дүрэм журмыг санал болгох
- Хөдөлмөрийн тухай болон хөдөлмөр эрхлэлттэй холбоотой бүхий л хууль дүрэм, журмын тухай сайтар мэдлэгтэй байж зайлшгүй шаардлагатай стандартуудыг дагаж мөрдөх үйл ажиллагааг хянах, үнэлэлт дүгнэлт өгөх
- Компанийн хэмжээнд шаардлагатай ажлын байрны дутагдал тогтоож шаардлагатай бол шинэ ажлын байр бий болгох, ажил үүргийн давхцал, гажуудал зэргийг илрүүлж ажиллах
- Зохистой хүний нөөцөөр хангах, ажилтнуудын ур чадварыг дээшлүүлж хөгжүүлэх төлөвлөгөө, төсөл, хөтөлбөрийг боловсруулж батлуулах, хэрэгжилтийг хангах, гүйцэтгэлийг тайлагнах

Тавигдах шаардлага
- Хүний нөөцийн менежмент, бизнесийн удирдлагын чиглэлээр магистр болон түүнээс дээш зэрэгтэй байх
- Хүний нөөцийн чиглэлээр удирдах албан тушаалд 8-с дээш жил ажилласан туршлагатай
- Хүний нөөцийн орчин үеийн шинэ хандлагуудыг судалж, байгууллагын соёлтой уялдуулан үйл ажиллагаанд нэвтрүүлэх чадвартай байх
- Компьютерын хэрэглээний болон мэдээллийн баазын программууд дээр чөлөөтэй ажиллах чадвартай байх
- Англи хэлний бичгийн болон ярианы өндөр чадвартай байх
- Гадаад мэргэжилтнүүдтэй хамтран ажиллаж байсан бол давуу тал болно

ХУУЛИЙН ХЭЛТСИЙН ЗАХИРАЛ

1 сарын цалин: 20 сая хүртэл
Бусад урамшуулал

Үндсэн үүрэг хариуцлага
- Компанийн хуулийн хэлтсийн өдөр тутмын үйл ажиллагааг удирдан зохион байгуулах
- Гадаад худалдааны болон худалдан авалтын гэрээ хэлцлийн төсөл боловсруулах, хянах
- Хөдөлмөрийн эрх зүйн талаарх өндөр мэдлэгтэй байх, хөдөлмөрийн харилцаатай холбоотой асуудлыг шийдвэрлэх
- Хууль, эрх зүйн бодлогын баримт бичгийн төсөл боловсруулах, төгөлдөржүүлж боловсронгуй болгох, хэрэгжилтэнд хяналт тавих
- Компанийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах, холбогдох байгууллага, шүүх, арбитрын байгууллагад төлөөлөх
- Байгууллагын үйл ажиллагааны хүрээнд хууль, эрх зүйн асуудлыг шийдвэрлэх
- Гэрээний төсөл боловсруулах, хэрэгжилтийг хариуцах, тайлагнах

Тавигдах шаардлага
- Хууль, эрх зүйн чиглэлээр бакалавр буюу түүнээс дээш зэрэгтэй байх
- Хуульчийн сонгон шалгаруулалтад тэнцэж, хуульчийн гэрчилгээ авсан байх
- Мэргэжлээрээ 8 буюу түүнээс дээш жил ажилласан ажлын туршлагатай
- Иргэний тухай хууль, Хөдөлмөрийн хууль, Ашигт малтмалын тухай хууль болон бусад холбогдох хууль тогтоомж, эрхзүйн актуудын талаар ахисан түвшний мэдлэгтэй байх
- Бусдад зөвлөгөө өгөх, тайлбарлан ойлгуулах, итгүүлэн үнэмшүүлэх чадвартай байх
- Ажилдаа идэвхи санаачлагатай, хариуцлагатай, өндөр ёс зүйтэй, үнэнч шударга
- Хэрэгцээтэй мэдээллийг хайх, олж авах, боловсруулах чадвартай
- Англи хэлний ярианы чадварыг бүрэн эзэмшсэн, англи хэл дээр гэрээ, контракт хянах чадвартай байх
- Компьютерын хэрэглээний програмуудыг өндөр түвшинд эзэмшсэн

"Их Говь Энержи" ХХК-ийн ажилд бүртгүүлэх өргөдлийн маягтыг оффист ирж бөглөх эсвэл анкетыг burmaa.b@ikhgobienergy.mn хаягаар илгээнэ үү.
Тодруулах зүйл байвал доорх хаяг, утсаар холбогдоно уу.

Монгол улс, Улаанбаатар, 14241, Сүхбаатар дүүрэг,
1-р хороо, Олимпийн гудамж, Шангри-Ла Оффис, 10 давхар
Утас: 88100447, 99064123

Спорт

ВВМ©

NBA-гийн баг худалдаж авах нь хамгийн ашигтай бизнес

Лигийн 30 багийн дундаж үнэлгээ 1.65 тэрбум ам.доллар болжээ

Г.Баярсайхан
@bayarsaikhanZGM

Америкийн бизнесмэн Лесли Александр 1993 онд NBA-гийн "Хьюстон Рокетс" багийг 85 сая ам.доллараар худалдаж авахдаа хожим энэ мөнгөө хэдэн арав дахин нугалж олно гэж төсөөлөөгүй биз ээ. Өнгөрсөн хорь гаруй жилд сагсан бөмбөг дэлхий даяар глобалчлагдаж, олон хүн энэ спортыг шимтэн сонирхдог болж, тэр хэрээр багуудын үнэлгээ эрс өсөв. Улмаар Александр 85 саяар авч байсан багаа өнгөрсөн жил 2.2 тэрбумаар худалджээ. Анхны үнэлгээнээсээ 25 дахин өссөн гэсэн үг. Тун ч ашигтай бизнес болсон байгаа биз.

Ер нь NBA-гийн багуудын үнэлгээ жил бүр эрс нэмэгдсээр байна. Forbes-ийн тооцоолсноор 2018 онд тус лигийн 30 баг бүгдээрээ анх удаа тэрбум ам.долларын үнэлгээг давж гарчээ. Дундаж үнэлгээ 1.65 тэрбумд хүрсэн нь жилийн өмнөхтэй харьцуулахад 22 хувиар өссөн үзүүлэлт байв. Одоогоос 10 жилийн өмнө багуудын дундаж үнэлгээ 372 сая байжээ. Аравхан жилийн хугацаанд бараг гурав дахин өссөн гэсэн үг.

"Чикаго Буллс" болон "Нью-Йорк Никс" багийн үнэлгээ хамгийн бага буюу дөрөв болон есөн хувиар дээшилсэн бол "Филадельфи"-гийн үнэлгээ 48 хувиар дээшилж, хөрөнгө оруулагчдын магнайг тэнийлгэжээ.

Тухайн баг том зах зээлтэй, том хотод оршдог бол үнэлгээ нь өндөр байдаг зүй тогтол бий. "Никс" гэхэд ойрын жилүүдэд тогтмол сүүлийн хэдэн байрт бичигдэж буй ч Нью-Йорк хэмээх том хотынх гэдэг утгаараа лигийн багуудыг үнэлгээгээрээ тэргүүлдэг. Тус баг бараг тоглолт бүртээ хожигдсон ч хамаагүй тасалбарын борлуулалт тун эрэлттэй. Тэд өнгөрсөн жил 426 сая ам.долларын орлого олсон нь бүх багийг тэргүүлэх үзүүлэлт болжээ.

Домогт сагсчин Майкл Жордан спортын салбараас төрсөн анхны тэрбумтан болсон нь саяхан. Тэгвэл түүнийг энэ алдарт хүргэсэн гол зүйл нь NBA-гийн "Шарлотт Хорнетс" багийг худалдаж авсан шийдвэр нь байв. Майкл 2006 онд энэ багийг 260 сая ам.доллараар авсан бол өдгөө багийн үнэлгээ нэг тэрбумд хүрээд байна. NBA-гийн багт хөрөнгө оруулах нь тун ашигтай бизнес гэдэг нь эндээс харагдах байх. Тиймдээ ч дэлхийн толгой баячууд энэ салбарыг асар их сонирхох болжээ.

Лигийн багуудын ашиг орлого нэмэгдэж, үнэлгээ өссөөр байгаа нь юутай холбоотой вэ. Үүнийг лигийн удирдлагууд сагсан бөмбөгийг олны хүртээл болгох ажлаа маш сайн хийж, зах зээлээ тэлж чадсантай холбон тайлбарлах нь зүйтэй. БНХАУ-д гэхэд сагсан бөмбөгийг сонирхон тоглодог 300 сая хүн бий. NBA энэхүү аварга зах зээлийг эзлэхийн тулд 2015 онд Tencent групптэй дижитал платформд хамтран ажиллах гэрээ байгуулсан. Энэхүү гэрээ NBA-г жил бүр 800 сая "ногоон"-оор тэтгэж буй. Өдгөө лиг өмнөд хөршийн 34 компанитай хамтран ажиллаж, үр дүнд нь 144 сая хүн сошиал ертөнц дэх NBA-гийн хэрэглэгч болжээ.

Телевизийн гэрээний эрх энэ лигийн ашиг орлогын гол үндэс болсон хэвээр. Лигийн удирдлагууд TNT болон ESPN сувагтай тоглолт шууд дамжуулах гурван жилийн гэрээ хийж, хариуд нь 24 тэрбум ам.доллар авсан. 1980-аад онд аваргын төлөөх тоглолтоо зурагтаар шууд дамжуулан үзүүлж чаддаггүй, дараа нь бичлэгээр хүргэдэг байсантай харьцуулахад энэ бол том дэвшил. Телевизийн гэрээний эрхийн мөнгөн дүн цаашид ч улам нэмэгдэнэ гэдэгт мэргэжилтнүүд санал нэгдэж байна. [ЗГМ]

NBA-гийн багуудын дундаж үнэлгээний өөрчлөлт
(сая ам.доллараар)



statista.com©

NBA-ГИЙН БАГУУДЫН ҮНЭЛГЭЭ

БАГ	ҮНЭЛГЭЭ (ТЭРБУМ $)	ЖИЛИЙН ӨӨРЧЛӨЛТ (%)	ОРЛОГО (САЯ$)
1.НЬЮ-ЙОРК НИКС	3.6	+9	426
2.ЛОС-АНЖЕЛЕС ЛЕЙКЕРС	3.3	+10	371
3.ГОЛДЕН СТЭЙТ УОРРИОРС	3.1	+19	359
4.ЧИКАГО БУЛЛС	2.6	+4	281
5.БОСТОН СЕЛТИКС	2.5	+14	257
6.БРУКЛИН НЕТС	2.3	+28	273
7.ХЬЮСТОН РОКЕТС	2.2	+33	296
8.ЛОС-АНЖЕЛЕС КЛИППЕРС	2.15	+7	257
9.ДАЛЛАС МАВЕРИКС	1.9	+31	233
10.МАИАМИ ХИТ	1.7	+26	253
11.САН АНТОНИО СПЭРС	1.55	+32	259
12.ТОРОНТО РЭПТОРС	1.4	+24	250
13.САКРАМЕНТО КИНГС	1.37	+28	240
14.ВАШИНГТОН ВИЗАРДС	1.35	+35	222
15.КЛИВЛЕНД КАВАЛЬЕРС	1.3	+10	280
16.ПОРТЛЭНД ТРЭИЛ БЛЭЗЕРС	1.32	+24	223
17.ФИНИКС САНС	1.28	+16	218
18.ОКЛАХОМА СИТИ ТАНДЕР	1.25	+22	222
19.ОРЛАНДО МЭЖИК	1.22	+33	211
20.ЮТА ЖАЗЗ	1.2	+32	221
21.ФИЛАДЕЛЬФИ-76	1.18	+48	184
22.ИНДИАНА ПЭЙСЕРС	1.17	+34	205
23.АТЛАНТА ХОУКС	1.15	+30	209
24.ДЕНВЕР НАГГЕТС	1.12	+26	202
25.ДЕТРОЙТ ПИСТОНС	1.1	+22	221
26.МИЛУОКИ БАКС	1.07	+37	179
27.МИННЕСОТА ТИМБЕРВОЛВЕС	1.06	+38	204
28.ШАРЛОТТ ХОРНЕТС	1.05	+35	202
29.МЕМФИС ГРИЗЛИС	1.02	+30	206
30.НЬЮ-ОРЛЕАНС ПЕЛИКАНС	1.0	+33	246
ЛИГИЙН ДУНДАЖ	1.65	+22	246

Forbes©

ЗГМ ТОВЧХОН

» НААДАМ

1500

Тамирчин. "Азийн хүүхдүүд" олон улсын өвлийн спортын анхдугаар наадмыг оролцох Монголын багийн ахлагчаар МҮОХ-ны Гүйцэтгэх зөвлөлийн гишүүн Ч.Амарсанааг томиллоо. Тус наадам 2019 оны хоёрдугаар сарын 08-17-нд ОХУ-ын Сахалин мужид зохиох бөгөөд спортын найман төрлөөр 20 улсын 1500 гаруй өсвөрийн тамирчин оролцох юм.

» ЖҮДО БӨХ

13

Бөх. Энэ оны хамгийн сүүлийн томоохон тэмцээн болох "Мастерс-2018" энэ амралтын өдрүүдэд БНХАУ-ын Гуанжоу хотноо болно. Цар хүрээ, чансаагаараа олимпийн наадам, ДАШТ-ий дараа ордог энэхүү тэмцээнд жин бүрт эхний 16-д бичигддэг тамирчид урилгаар оролцдог юм. Манайхаас эрэгтэй 10, эмэгтэй гурав, нийт 13 бөх оролцохоор эх орноосоо мордлоо.

» САГСАН БӨМБӨГ

Өчигдөр болсон "Бостон Селтикс", "Вашингтон Визардс" багуудын тоглолтын дундуур монгол хүүхдүүд ардын урлагийн тоглолтоо сонирхуууллаа. NBA-гийн талбайд монголчууд урлагийн номер толилуулсан анхны тохиолдол нь энэ болсон байна. Тэрхүү тоглолт тун өрсөлдөөнтэй болж, зочин баг "Селтикс" нэмэлт цагт 130:125-аар ялалт байгууллаа.

» ШАГНАЛ

2018 оны Монгол Улсын шилдэг эрэгтэй хөлбөмбөгчөөр "Улаанбаатар сити" клубийн зүүн жигүүрийн хагас хамгаалагч Н.Цэдэнбал тодорлоо. Тэрбээр Зүүн Азийн АШТ-ий урьдчилсан шатанд Гуамын хаалганд цаг дуусах мөчид чухал гоол оруулж, багаа дараагийн шатанд шалгаруулсан юм. Н.Цэдэнбал энэ жил шигшээ багт 10 тоглолт хийхдээ хоёр гоол оруулж, дөрвөн гоолын дамжуулалт өгчээ. Мөн "Улаанбаатар сити" клубийнхээ хамтаар "Супер цом"-ын аварга болж, МХБХ-ны цомын тэмцээнд аман хүзүүдсэн билээ.

» ХӨЛБӨМБӨГ

4

Баг. Европын хөлбөмбөгийн Аваргуудын лигийн хасагдах шатанд өрсөлдөх шилдэг 16 баг тодорлоо. Английн дөрвөн баг энэ тэмцээнд оролцсоноос дөрвүүлээ бага шөвөгт үлдсэн байна. Мөн Испани, Германы тус бүр гурван баг энэ давааnд шалгарчээ.

» ЦАНА

Гүйлтийн цаны шилдэг тамирчдын нэг Норвегийн Петер Нортуг спортын замналаа өндөрлүүлж буйгаа зарлалаа. Цаны спортод урьдын адил хүч чадлаа зарцуулах боломжгүй болсон тул ийм шийдвэр гаргасан байна. Нортуг олимпийн наадамд хоёр, ДАШТ-д 13 удаа түрүүлсэн юм. Гэвч 2016 оноос хойш Дэлхийн цомын нэг ч гараанд түрүүлж чадаагүй аж.

ОЛИМПИЗМ

МҮОХ-ны ерөнхийлөгч Д.Загдсүрэн ажлаа өгнө

Б.Энхжин
ЗГМ

МҮОХ-ны ерөнхийлөгч Д.Загдсүрэнд 2018 оны арваннэгдүгээр сард Монгол Улсын хуулийн дагуу тэтгэвэр тогтоолгох эрх нээгдэж байгаа аж. Тиймээс МҮОХ-ны Ээлжит бус чуулганыг 2019 оны дөрөвдүгээр сарын 25-ны өдөр хуралдуулж, ерөнхийлөгчийн сонгуульт ажлаа хүлээлгэн өгөх хүсэлт гаргажээ. Тэрхүү хурлаар шинэ ерөнхийлөгчийг

сонгох юм.

МҮОХ-ны дүрмийн 16.6-д "Шаардлагатай тохиолдолд МҮОХ-ны ээлжит бус чуулган болон Гишүүдийн хурлыг нийт санал өгөх эрхтэй гишүүдийн 75-аас дээш хувийн эсвэл Гүйцэтгэх зөвлөл, Ерөнхийлөгчийн бичгээр гаргасан саналыг үндэслэн хугацаанаас нь өмнө зарлан хуралдуулж болно. Ээлжит бус хурал нь ээлжит хуралтай ижил горимоор болно" хэмээн заасан байдаг аж. Д.Загдсүрэн 2001 оноос хойш МҮОХ-г удирдаж байгаа юм. [ЗГМ]

ZGM DAILY

PM Khurelsukh Ukhnaa meets Shinzo Abe

Sides discussed potential free trade agreement between Mongolia and Japan.

Experts warn of potential risk in export plan next year

Bloomberg Economists are predicting coal price to fall by around USD 14 in 2019.

Non-performing loans reaches MNT 2 trillion in November

Total outstanding loans of private entities and individuals stands at MNT 16.7 trillion.

US Army officer found dead in Shangri-La Hotel, Ulaanbaatar

Evidences at the crime scene suggest suicide.

Mongolia to inaugurate Trade Representatives Office in Tokyo

PM Khurelsukh meets his Japanese counterpart Shinzo Abe

Tugsbilig.B
@tugsbiligZGM

Prime Minister Khurelsukh Ukhnaa met with his Japanese counterpart Shinzo Abe yesterday and held discussion on free-trade agreement. At the end of the meeting, sides released a joint statement, in which the sides officially announced to implement a Master Plan on Creating Value-Chain via Sustainable Development of Agriculture.

Key highlights of the statement:

Mongolian Government is now obliged to finalize the negotiation of concession agreement on a new airport in Khushigiyn Valley within January 2019 and inaugurating the airport within next year. In turn, the Japanese Government expressed on continuing the support on consortium activities.

Acknowledging the massive potential in Mongolia, sides expressed to intensify public and private cooperation in tourism.

The PMs agreed on supporting technical cooperation in cashmere production, building the capacity of cashmere companies and intensifying the promotion of Mongolian cashmere in Japanese market.



ZGM©

Mongolia and Japan held discussion on free-trade agreement.

On the sidelines of his official visit to Japan, Prime Minister Khurelsukh Ukhnaa met with the Chairman of the Japan External Trade Organization (JETRO) Hiroyuki Ishige yesterday and attended the 9th Mongolia-Japan Public and Private Sector Joint Committee meeting, during which the PM announced to establish Trade Representative Office in Tokyo.

During the meeting, sides exchanged views on the progress of implementation of Mongolia-Japan Economic Partnership Agreement. Mr. Hiroyuki Ishige expressed his delight with the improvement of bilateral trade turnover and business relations and stressed that Japanese firms face difficulties in doing business in Mongolia and asked the Prime Minister to pay attention to it.

PM Khurelsukh said that Mongolian government is giving great importance to the protection of investors' interest and working to establish Trade Representative Office in Tokyo in order to provide foreign investors with comprehensive investment on information and increase opportunities for their business development. Prime Minister expressed willingness to cooperate closely with JETRO on implementation and efficiency improvement of the Economic Partnership Agreement, which took effect in June 2016, and announced that a One-Stop Service will be available for investors starting from January 1, 2019.

At the 9th Mongolia-Japan Government and Business Sector Joint Committee meeting, Director General of the National Development Agency Bayarsaikhan Banzragch presented the current state of economy, development policy planning, internal and external environment for investments, tax and non-tax support, advantages, opportunities and statistics, and introduced the Government activities to support FDI in detail.

PM addressed, "Mongolian Government is paying special attention in maintaining economic stability, improving the legal environment for doing business. Mongolia is successfully overcoming the economic difficulty that it faced in recent years. As a result of several measures on protecting investors' interest and restoring their confidence, FDI in Mongolia significantly grew since 2017. For instance, the FDI jumped by around 30 percent yoy as of the third quarter of this year."

He then asked about the difficulties in doing business in Mongolia. In response, Kazuhiro Osonoe, CEO of Takarajima Japan LLC, highlighted Mongolians' credence as a major risk factor. Mr. Kazuhiro Osonoe suggested, "Accountability is crucial for Mongolia to attract investment. Japan has the technology, knowhow and assets, while Mongolia has the opportunity." [ZGM]

ZGM: HIGHLIGHTS

POLITICS

Parliament fails to form quorum once again. Discussion on appointing the next Minister of Food, Agriculture and Light Industry, as well as the revision to the Law on Currency Regulations postponed.

State Secretary of the Ministry of Foreign Affairs Davaasuren Damdinsuren receives a delegation led by Gregory Lecomte, Project Manager at the OECD Eurasia Competitiveness Program. Sides discussed the opportunities to the leading practices of OECD member states.

ECONOMY

Ulaanbaatar Railway Joint Venture announces that freight transports hit a record-high this year and is expected to reach 25 million tons this year. The company had an initial goal to transport 24.5 million tons of freight this year.

Top 20 Index falls 1.12 percent, to 19,672.25 points. MSE A Index drops 1.09 percent, to 9,435.99 percent. MSE B Index grows 1.13 percent, to 8,774.56 points. Market cap stands at MNT 2.33 trillion.



SOCIETY

"Mongolian Ger" documentary directed by Unurtogtokh Batjargal was named as the Best Documentary at an annual International Documentary Film Festival held in South Korea which involved documentaries from over 130 countries.

Pyotr Ilyich Tchaikovsky's the Nutcracker to be staged on December 22 and 23 at the Mongolian State Academic Theatre of Opera and Ballet.

Scan the QR code for further information and to purchase the ticket.

FX MARKET







FOREIGN TRADE

Experts warn of potential obstruction to export plan in 2019

Analysts of the economist club of Bloomberg TV Mongolia warn of potential risk in meeting export and budget revenue plans driven by prices of key export commodities and border situation that could affect the economy in 2019.

Bloomberg economists suggested the need to immediately settle infrastructure issues to boost budget revenue. Within this frame, holding talks with the People's Republic of China and reaching deals on improving the entry capacity at the border, stimulating transports and establishing the second major border checkpoint.

Economists are predicting coal price to fall by around USD 14 in 2019. Mongolia exported a total of 2.5 million tons of coal in November, which is the lowest amount in the last nine months. This decrease was mainly affected by China's renovation at the border, causing temporary interruption for coal transport. Additionally, World Bank Group, Bloomberg and Bree released their outlook on coal price in 2019.

As for budget expense, the bloomberg experts highlighted the risk that half of investment expenditure would flow into import. Thus, analysts recommended to take preventive measures on import growth and set the implementation schedules apart to cut budget expense. [ZGM]

BREAKING NEWS

U.S military staff found dead in Ulaanbaatar

Khasui.B / ZGM©

On Wednesday, United States Army officer was found dead at the Shangri-La Hotel, Ulaanbaatar. The 34-year old male was reportedly on a visit to Mongolia within the frame of cooperation between the Ministry of Defense of Mongolia and U.S House Democracy Partnership. Although the evidences at the crime scene suggest potential suicide, the cause of death is unknown until the forensic results are available.

The Police Authority confirmed the case and informed that a case has been opened at the first Division of Sukhbaatar District Police and refused to give further details as the investigation started only recently. Minister of Defense Enkhbold Nyamaa also refused to provide any information while the Minister of Foreign Affairs is currently on an official visit to Japan.

When we contacted the U.S Embassy in Ulaanbaatar, the embassy wrote, "Department is deeply saddened by the news of the passing of the U.S. Army officer visiting Mongolia. We extend our deepest condolences to his family and loved ones. Officials from the Departments of State and Defense are working with Mongolian authorities to ensure all matters are properly and respectfully handled. We extend our gratitude to the Government of Mongolia for their support and assistance. Out of respect for the families involved we have nothing further to share at this time."

ZGM Daily will continue to report the results of the investigation. [ZGM]

BANKING SECTOR

Non-performing loans grow 78.8 percent yoy

National Statistics Office report shows that non-performing loans (NPL) drastically surged in October and November. NPLs in the banking system reached MNT 2 trillion, which is 78.8 percent higher than the same period of last year. In month-over-month comparison, NPLs jumped by MNT 106.6 billion. This shows that NPLs account for 12.4 percent of total gross loans, a 3.8 percentage point growth year-over-year (yoy).

In the reporting period, the total outstanding loans of private entities and individuals stands at MNT 16.7 trillion, a 23.9 percent growth yoy and MNT 263.1 billion higher than the previous year. As of November 2018, the amount of overdue loans slightly fell to MNT 974 billion.

Money supply (M2) reached MNT 18.6 trillion in November, displaying 1.8 percent growth compared to the previous month and 25.9 percent surge yoy. The currency issued in circulation totalled MNT 895.1 billion in November, an 8.5 percent increase compared to the same period of last year. [ZGM]

Өдрийн хэмнэл

ТВ ХӨТӨЛБӨР

MNB

09:45	Сулд
10:05	Судар бичгийн алтан сан: "Үлгэрийн далай"
15:25	Спортын хэлэлцүүлэг: Өвлийн спорт, аялал жуулчлалын асуудлаар
18:25	"Эгнэгт ивээх Эрдэнэтийн овоо"
21:10	"Хайрлаарай" ярилцлага
23:00	Миний ард түмэн: "Барга"

Bloomberg TV Mongolia

07:00	"Суутнуудын намтар" нэвтрүүлэг
11:00	#MadeInMongolia" нэвтрүүлэг
14:00	"Дэвид Рубенштэйний шоу" нэвтрүүлэг
20:00	"Блумбергийн ярилцах цаг" нэвтрүүлэг
21:00	"Мөнгөний урсгал" хөтөлбөр
22:00	"Суутнуудын намтар" нэвтрүүлэг

БОЛОВСРОЛ HD

08:10	"Тобот" хүүхэлдэйн кино 1.27-28-р анги
11:35	Үүнийг хэрхэн хийдэг вэ?
13:00	"Монголчууд XX зууны эхэнд" нэвтрүүлэг
14:10	"Аяыг таа" шоу нэвтрүүлэг
20:40	"Хүрээлэн" амьд ертөнц нэвтрүүлэг
22:05	"Ээж" ОАК 77-р анги

МОНГОЛ TV

06:00	"Сонсъё, Суръя, Дагая" / season-1/ 41-р анги
12:00	Хөтөч мэдээллийн хөтөлбөр
13:30	"Ан амьтдын ертөнцөөр" /season-9/ 8-р хэсэг
17:30	"Мөрдөгч хүүхдүүд" ОАК /season-2/ 49,50-р хэсэг
19:00	Оргил цаг мэдээллийн хөтөлбөр
21:30	"Америкчууд" ОАК / season-5/ 5-р анги

ЗУРХАЙ



Билгийн тооллын 6
Өвлийн дунд хөх хулгана сарын есөн улаан мэнгэтэй цагаан луу өдөр
Үс засуулбал: Хэл ам, хэрүүл тэмцэл ирнэ
Наран ургах, шингэх: 08.32-17.04
Барилдлага: Шид
Шүтэн барилдлага: Хүрэлцэхүй
Суудал: Үс

Аргын тооллын арванхоёрдугаар сарын 14, Сугар гараг. Билгийн тооллын 7, Чөдөр одтой, цагаан луу өдөр. Өдрийн наран 08.32 цагт мандан, 17.04 цагт жаргана. Тухайн өдөр хулгана, бич жилтнээ аливаа үйлийг хийхэд эерэг сайн ба бар, туулай жилтнээ сөрөг муу нөлөөтэй тул элдэв үйлд хянамгай хандаж, биеэ энхрийлүүштэй. Эл өдөр буян номын үйлд шамдах, бүтээл туурвил эхлэх, худалдаа арилжаа хийх, бизнес эхлэх, зэрэг дэвших, хишиг дайллага дуудуулах, насан бүтээл хийлгэх, зэтгэрийг номхотгох, хөгжмийн зэмсэг урлах, хур оруулах, дархны үйлд сайн. Гүүр тавих, газар шороо ухахад муу. Өдрийн сайн цаг нь барс, луу, морь, бич, тахиа, гахай болой. Хол газар явахаар одоогсод зүүн зүгт мөрөө гаргавал зохистой. Үс шинээр үргээлгэх буюу засуулахад тохиромжгүй.

"Шоколадтай шинэ жил"
Хэзээ: 2018.12.16-ны 13.00 цагт
Хаана: МУЭСТО
Тасалбарын үнэ: ₮30 мянга

"Бумбардай" жүжиг
Хэзээ: 2018.12.22-ны 13.00 цагт
Хаана: Чойжин сүитс
Тасалбарын үнэ: ₮40 мянга

У.Шекспир "Ромео, Жульетта"
Хэзээ: 2018.12.20-22-ны 19.00 цагт
Хаана: УДЭТ
Тасалбарын үнэ: ₮10-30 мянга

ОНЦЛОХ ҮЗВЭР



Питер Паркерийг бид бүгд мэднэ. Тэр хотыг аврагдаг, дурладаг, дараа нь дахиад хотыг аврагдаг гэх цааш үргэлжилнэ. Хэрэв аврагч том коллайдер нээгдэж, нэг хэмжээст ертөнцөөс өөр нэг ертөнц рүү тэр орчихвол яах бол. Өнөөх паралель ертөнцөд нь өөртэй нь ижилхэн бас нэг Хүн-аалз байвал юу болох вэ. Хүн аалзнууд нэг дор цуглаад, барaг ялагдашгүй дайсны эсрэг тэмцэнэ гэд төсөөл дөө. Энэ бол алдарт Хүн-аалз цувралын хамгийн сүүлийн ангийн товч танилцуулга. Columbia Pictures болон Sony Pictures-ийн хамтын бүтээл Spider-Man: Into the Spider-Verse бүрэн хэмжээний хүүхэлдэйн кино өнөөдөр дэлхий дахинд нээлтээ хийж байна. Үүнтэй зэрэгцэн "Өргөө" кино театрын дэлгэцээр мөн гарч эхлэх юм. Хүн-аалзын шинэ цуврал 117 минут үргэлжлэх бөгөөд нийт 90 сая ам.долларын өртөгтэй бүтжээ. Нээлтийн өдрөө АНУ, Канадын 3800 кино театр зэрэг гарч, эхний долоо хоногтоо 30-35 сая ам.долларын орлого олох төлөвтэй байгааг тооцоолсон байна. [ЗГМ]

Шинэ жилийн "Prosit 2019" тоглолт
Хэзээ: 2018.12.17-ны 19.00 цагт
Хаана: УДБЭТ
Тасалбарын үнэ: ₮10-50 мянга.

"Орчлонгийн аяс" хамтарсан тоглолт
Хэзээ: 2018.12.14-ны 19.00 цагт
Хаана: Цэргийн дуу бүжгийн эрдмийн чуулга
Тасалбарын үнэ: ₮25 мянга

"Щелкунчик" балет
Хэзээ: 2018.12.15,16-ны 12.00, 17.00 цагт
Хаана: УДБЭТ
Тасалбарын үнэ: ₮ 10-30 мянга

ЦАГ АГААР

УЛААНБААТАР

	XII.14	XII.15	XII.16	XII.17	XII.18
Өдөр	-11° 6 м/с	-11° 7 м/с	-10° 7 м/с	-9° 8 м/с	-11° 6 м/с
Шөнө	-19° 5 м/с	-20° 5 м/с	-21° 5 м/с	-18° 6 м/с	-18° 5 м/с
	Багавтар үүлтэй	Үүлшинэ	Үүлшинэ	Үүлшинэ	Ялимгүй цастай



ФОТО АГШИН

Өвлийн хүйтэнд ус зөөнө гэдэг хүүхдэд ахадсан хүчир ажил ч тэдэнд сонголт үгүй.

С.Батсайхан / ЗГМ©

ЗГМ: СҮДОКУ

3		7			6			
					7	1		
6				4		9	5	
	7	9				6		8
	4		7		5			
			2				4	
		8		3				
7		1						
							6	4

(Өмнөх дугаарын хариу)

6	8	2	4	7	9	5	3	1
3	9	5	6	1	8	2	7	4
7	1	4	5	2	3	9	8	6
8	7	6	2	5	4	3	1	9
1	5	3	8	9	6	4	2	7
4	2	9	1	3	7	8	6	5
9	4	8	7	6	2	1	5	3
2	6	1	3	4	5	7	9	8
5	3	7	9	8	1	6	4	2

ГАЛТ ТЭРЭГНИЙ ЦАГИЙН ХУВААРЬ

ЭРЭЭН-УБ	18.00	11.15
УБ-ХӨХ ХОТ	20.00	20.49
ХӨХ ХОТ-УБ	22.50	11.15
УБ-ЭРХҮҮ	21.10	02.40
ЭРХҮҮ-УБ	15.35	06.20
УБ-СҮХБААТАР	21.15	05.12
СҮХБААТАР-УБ	20.55	05.03
УБ-ЭРДЭНЭТ	20.30	07.45
ЭРДЭНЭТ-УБ	19.10	05.48

НИСЛЭГИЙН ЦАГИЙН ХУВААРЬ

УБ-БЭЭЖИН	17.15	19.30
БЭЭЖИН-УБ	20.30	23.00
УБ-ХОНКОНГ	07.50	12.25
ХОНКОНГ-УБ	13.25	18.05
УБ-СӨҮЛ	07.45	12.05
СӨҮЛ-УБ	13.20	16.05
УБ-ТОКИО	08.55	14.30
ТОКИО-УБ	15.30	20.25
УБ-ХӨХ ХОТ	10.30	12.00
ХӨХ ХОТ-УБ	13.00	14.40

ЗГМ: ҮГИЙН СҮЛЖЭЭ



БОСООГООР:
1. Дэлхийн хамгийн том амьтан
2. Үнэгний зулзага
3. Нүүрний чихнээс доош хэсэг
4. Ертөнцийн гурван хөөрхөний нэг
5. Халхавч
6. Төл мал
7. Үлээвэр хөгжим
13. Хөгжмийн бага хэмжээний зохиол, аялгуу
14. Аялал
16. Агаарт дэгдсэн уурны бөөгнөрөл
17. Аймаг орон нутаг дахь эрүүлийг хамгаалах байгууллага (товчилсон нэр)
18. Биеийн төлөөний нэр
19. Буурал тивийн гол байгууллага (товчилсон нэр)

ХӨНДЛӨНГӨӨР:
1. Цаа бугын төл
5. Хандгайн төл
8. Агаар мандалд хуримтлагдсан цахилгаан цэнэг газарт буух үзэгдэл
9. Хамба ламын эзгүйд хурал удирдах лам
10. ... халуун
11. Ан цав
12. Хужир давслаг зурвас
15. Түлш
20. Цана

Өмнөх дугаарын хариу / 12.13

ОЛЖ ӨГЧ ТУСАЛНА УУ

Сэлэнгэ аймгийн Баянгол сумын харьяа "Эртний нуга" ХХК-ийн 0210094 тоот регистрийн дугаартай газрын гэрчилгээ гээсэн тул олж өгч тусална уу?

ЭДИЙН ЗАСАГ

Т.Мэй Ерөнхий сайдын албаа авч үлдлээ

Намынхаа санал хураалтыг давсан ч Тереза Мэйг ЕХ-оос гарах гэрээг батлуулах ширүүн тэмцэл хүлээж байна.

> 10

Uber болон Alphabet хотын тариаланд хөрөнгө орууллаа

Bowery Farming старт-ап хүлэмжид ногоо тарихдаа робот ашиглаж, өсөлтийн зам дээр гарчээ.

> 10

2019 онд ам.доллар унаж, иен чангарах төлөвтэй

Ирэх жил ам.доллар унаж болзошгүй ч валютын стратегичид Японы иенд гол найдвараа тавьж байна.

> 10

ДЭЛХИЙ

Хятадын баячуудын оффшор хуримтлал $1 их наядад хүрлээ

Татварын шинэ зохицуулалт гадаадад траст байгуулах бизнесийг Хятадын баячууд тэжээн тэтгэх нөхцөл үүсгэв.

BBM©

◀1

Татварын албаны өнцгөөс харвал гар сунгах төдий зайтай гадаадад траст байгуулах асуудлаар мэргэшсэн зөвлөх, хувийн банкны эзэд, хуульчидтай холбоотой бизнесийг Хятадын баячууд тэжээн тэтгэх нөхцөл үүсээд байна. Мөн хугацаанд Хятад орны баячууд улам баян болсоор.

Тус улсын хувийн мэдлийн хөрөнгө 2017 онд 21 их наяд ам.долларт хүрсэнтэй уялдан хөрөнгөө гадаадад гаргах, татварын харьяаллын статусаа солих үзэгдэл нийтлэг болж хувирав. Засгийн газар эрсдэлтэй M&A (худалдаж авах, нэгтгэх) хэлцлийг цөөрүүлэх, хөрөнгө гадагш гарах явдлыг хязгаарлахаар өнгөрсөн онд мөнгөний урсгалд хатуу хяналт тогтоосон ч энэ жил хятадуудын оффшор хөрөнгө нэг их наяд ам.доллар давах төлөвтэйг Boston Consulting Group Тооцоолжээ.

“Оффшор траст байгуулах, хөрөнгийн Хятад дахь бүртгэлээ цуцлуулах сонирхол үлэмж өссөн”-ийг Шанхайд төвтэй консалтингийн Zhong Lun компанийн татварын мэргэжилтэн Питер Ни ярьж байлаа. “Хэт их орлоготой хүмүүс 2019 оноос хэрэгжих зохицуулалтаас өмнө амжуулахаар яарч байна”.

Хятадын толгой баячуудын зарим нь хэдийн траст байгуулчихсан. Үл хөдлөх хөрөнгийн эзэнт гүрнийг үндэслэгч Ву Яжунь 7.5 тэрбумаар хэмжигддэг хөрөнгийнхөө бараг хагасыг нь Каймaны арлуудад бүртгэлтэй Longfor Group Holdings-ын нэр дээр, гэр бүлийн трастаар дамжуулан эзэмшиж байна. Хатагтай Ву охиныхоо нэр дээр байгуулсан дахиад нэг трастад сарын өмнөхөн хөрөнгө шилжүүлжээ.

Траст эзэмшигч асар баян хятадуудын нэг нь Жан Шипин. Тэрбээр Хятадын хөнгөн цагааны тэргүүлэх үйлдвэрлэгчийн нэг China Hongqia Group-ын хяналтын хувьцааг мөн л Каймaны арлуудад траст ашиглан эзэмшиж байгаа.

Хилийн чанад дахь Хятадын оффшор хөрөнгө 2012-2018 оны хооронд хоёр дахин өслөө
(нэг их наяд ам.доллар 500 тэрбум ам.доллар)



Тайланд валют 2018 онд хөгжиж буй зах зээлд шилдэг нь болов



BBM©

Юми Тесо

Хүнд бэрх үеийн дараа сайн сайхан цаг ирдгийг Тайландын мөнгө – бат чухам харуулж чадлаа. Ам.доллартай харьцуулсан тай батын ханш Бангкокт лхагва гарагийн 14.20 цагийн байдлаар 0.6 хувиар суларч, 32.785-тай тэнцэх болсон нь Bloomberg-ийн судалгаанд хамрагдсан хөгжиж буй зах зээлийн валютууд дотроо шилдэг үзүүлэлт болов. Урсгал дансны ашиг, гадаад валютын нөөц ихэссэн нь Холбооны Нөөцийн Системийн чанга бодлого, Вашингтон, Бээжингийн худалдааны зөрчлөөс үүдэлтэй таагүй нөхцөлийг зөөлрүүлж чадлаа.

Тайландын урсгал дансны ашиг 2014 оны есдүгээр сараас хойш сар бүр ашигтай гарч ирлээ. Дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хувиар тооцвол гуравдугаар улирлын ашиг 7.7 хувьтай байгаа нь Азидаа хоёрдугаарт буюу 13 хувьтай Тайванийн дараа орж байна.

Экспортын ашиг 2017, 2018 оны тус бүр нэг сараас бусад бүх сард ашигтай гарсан нь Тайландын валютын эрэлт хэрэгцээ ихсэх нөхцөл бүрдүүлжээ. Сулрах шинж илэрсээр байгаа ч аялал жуулчлал тус улсын эдийн засгийг урагшлуулагч гол хөшүүрэг хэвээр. Бараа, үйлчилгээний экспорт Зүүн өмнөд Азийн хоёр дахь гол эдийн засгийн 70 орчим хувийг эзэлж байна.

Гадаад валютын нөөц 203 тэрбум ам.долларт хүрсэн нь ОУВС-гийн “хангалттай” гэж үздэг түвшнээс бараг хоёр дахин их байна.

Тайландын төв банк 2011 оноос хойш анх удаа бодлогын хүүгээ ирэх долоо хоногт өсгөхөөр төлөвлөж байгаа нь ч батын байр суурийг бэхжүүлж өгнө.

Эдийн засаг сэргэж, инфляц намжиж буйтай зэрэгцээ бондын зах зээлд энэ оны арванхоёрдугаар сарын 11-ний байдлаар 9.2 тэрбум ам.доллар орж ирсэн нь Тайландын валютад дэмжлэг боллоо. Өнгөрсөн 2017 онд 3.9 хувиар өссөн Тайландын эдийн засаг энэ жил 4.5 хувиар өссөн дүнтэй гарна хэмээн тус улсын Сангийн яам таамаглав. Тайландын инфляц арваннэгдүгээр сард 0.94 хувьтай байжээ. Тус улсын Худалдааны яам инфляц нэг орчим хувьтай байвал эдийн засагт хамгийн тохиромжтой хэмээн үздэг.

“Тайланд шиг эдийн засаг нь сайжирч, инфляц буурч буй улс тийм олон байхгүй”-г Бангкокт төвтэй Krung Thai Bank-ны ахлах эдийн засагч Житипол Пуксаматанан тайлбарлав. Энэ оны эцэс гэхэд ам.доллартай харьцуулсан батын ханш 30.7 болно хэмээн эдийн засагч тооцоолж байна.

Тайландын валютын нөөц хөгжиж буй эдийн засгууд дотроо хамгийн сайн байна



Улс бүрийн гадаад валютын нөөцийг ОУВС-гийн “хангалттай” гэж үздэг түвшинтэй харьцуулсан өсөлт.

ОУВС©

Пол Аллений өмчөөс $125 саяыг дархлаа судлалд зориулна

Симоне Фоксман

Нас барснаас нь хойш анхны томоохон филантроп бэлэг болгон Пол Аллены хөрөнгөөс 125 сая ам.долларыг дархлалын тогтолцоо, дархлалын өвчин эмгэг судлах судалгааны хүрээлэн байгуулахад зарцуулахаар боллоо.

Аравдугаар сард 65-тайдаа нас барахын өмнө ажиллаж байсан төсөл - Аллены Дархлаа Судлалын Хүрээлэнгийн ажлыг эхлүүлэхээр Microsoft-ыг үндэслэгч амласныг Аллены Хүрээлэн лхагва гарагт мэдэгдэв. Ашгийн бус дархлаа судлалын хүрээлэн нь Аллений Хүрээлэнгийн дөрөв дэх салбар болох юм. Тус хүрээлэнгийн бусад салбар эс, тархины судалгаанд төвлөрдөг.

Ходжкиний бус лимфом хавдрын хүндрэлээр нас нөгчсөн Аллений хөрөнгөөс буяны үйлсэд зориулж байгаа нь “гуниг, баяр давхацсан” хэрэг болж байгааг тус хүрээлэнгийн гүйцэтгэх захирал Аллан Жонс мэдэгдлээ. Бусад хүрээлэн нь шинжлэх ухааны судалгаанд амжилт гаргаж буйтай зэрэгцэн “анх удаа хүний эрүүл мэндийг хамгаалах үйлст шууд хэрэглээ болох учиртай ажилд дорвитой хөрөнгө оруулж байгаа”-г ноён Жонс өгүүлэв.

Пол Аллен Microsoft-ыг орхисноосоо хойших 30 жилд бизнес, буяны олон ажил үйлст гар бие оролцож иржээ. Giving Pledge санаачилгад нэгдсэнээсээ хойш тэрбээр 26 тэрбум ам.долларынхаа лавтайяа хагасыг нь хандив, буяны үйлст зориулсан бололтой. Түүний санхүүжилтээр 2003 онд байгуулсан Аллений Хүрээлэнд эдүгээ 500 орчим хүн ажилладаг. Хүрээлэнгийн удирдах зөвлөлд Аллений эгч багтдаг юм. Шинэ хүрээлэнгийн төлөвлөгөөнд 60-100 хүүхэд, залуу, ахмад настнаас сайн дурын үндсэн дээр өгөгдөл цуглуулах замаар дархлалын тогтолцоонд нь үүсэх өөрчлөлтийг урт хугацаанд судлан шинжлэх ажил багтаж байгаа. Судалгааны ажилд хүрээлэнгийн 70 эрдэмтний зэрэгцээ бусад эмнэлэг, судалгааны төвүүд хамрагдана.

Morgan Stanley шинэ сандаа 1.4 тэрбумыг хуримтлуулав

Сонали Басак

Morgan Stanley шинээр байгуулсан хувийн хөрөнгө оруулалтын сандаа 1.4 тэрбум ам.доллар төвлөрүүлж чадсан нь анх төлөвлөснөөс нь бараг гурав дахин илүү гарлаа. Төвлөрүүлсэн хөрөнгийг уг санд оролцогч хөрөнгө оруулалтын банк, баялгийн сангууд ашиглах юм. Шинэ санг “Волкерын дүрэм” (Volcker Rule) үйлчилж буй цаг үеийн шаардлагад нийцүүлэн байгуулсныг Morgan Stanley Investment Management-ын хувийн үнэт цаас, зээл хариуцсан тэргүүн Дэвид Миллер тайлбарлав.

Бээжин АНУ-аас хоёр сая хүртэл тонн шар буурцаг захиална

Шрути Синг

Зах зээлд хүлээсэн юм ёсоороо болж, БНХАУ шар буурцгийг АНУ-аас асар их хэмжээгээр авах шинж тодорлоо.

Хятадын импортлогчид ганц өдөр буюу 24 цагийн дотор АНУ-аас 1.5-2 сая тонн шар буурцаг худалдан авах гэрээ байгуулж амжсаныг АНУ-ын Шар Буурцгийн Экспортын Зөвлөл статистик тулгуурлан мэдээлэв. Захиалгын дагуу шар буурцгийг ирэх оны эхний улиралд багтаан нийлүүлнэ хэмээн тус зөвлөлийн гүйцэтгэх захирал Жим Саттер тайлбарлав.

Азийн эрчим хүч хэмнэх компани 33 саяын хөрөнгө оруулалт татав

Жойс Ко

Сингапурын эрчим хүч хэмнэх технологийн Barghest Building Performance (BBP) компанийн 45 сая сингапур долларын (33 сая ам.доллар) хувьцааг АНУ-ын хөрөнгө оруулалтын KKR & Co худалдан авлаа. Уг наймааны дүнд Сингапурын хувийн компани анх удаа дэлхийн зах зээлээс хөрөнгө оруулалт татаж чадав.

BBP-гийн хувьд хөрөнгө төвлөрүүлэх B цувралын санхүүжилтэд багтаж буй энэхүү хөрөнгө оруулалтыг Ази тивд цахилгаан эрчим хүчний хэрэглээг бууруулах технологид зарцуулах юм.

Компьютер үйлдвэрлэгч Hewlett-Packard, зочид буудлын Shangri-La сүлжээ зэрэг үйлчлүүлэгч нь BBP-гийн технологид тулгуурлан барилгын цахилгааны хэрэглээг 35 хувиар бууруулахаар төлөвлөж байна.

Эдийн засаг

ДЭЛХИЙ

Т.Мэй Ерөнхий сайдын албаа авч үлдлээ

Сидни Маки

Энэ удаад Британийн Ерөнхий сайд суудалдаа үлдсэн боловч байр суурь нь нэлээд суларсан байна.

BBM©

Ерөнхий сайдад итгэл үзүүлэх эсэх асуудлаар Британийн эрх баригч намын парламентын гишүүдийн дунд лхагва гарагт болсон санал хураалтыг Тереза Мэй давж гарлаа. Гэхдээ түүнийг Европын холбооноос гарах гэрээг батлуулах ширүүн тэмцэл хүлээж байна. Консеватив намаас парламентад суугаа гишүүд нууц санал хураалтаар 200:117-ын харьцаагаар хатагтай Мэйг намын удирдлагад үлдээхийг дэмжлээ. Энэ нь түүнийг эсэргүүцэгчид нэг жилийн хугацаанд намын тэргүүнээс авч хаях оролдлого хийж чадахгүй гэсэн үг юм.

Мэй телевизийн сэтгүүлчдийн өмнө ярихдаа "Намайг дэмждэг олон гишүүн эсрэг санал өгсөн. Би тэдний хэлсэн үгийг сонссон" гэжээ. Тэрбээр шүүмжлэгчидтэй тусгай уулзалт хийхдээ "2022 оны сонгуульд би та бүхнийг тэргүүлэхгүй гэдгээ мэдэж байна" хэмээн буулт хийсэн үг хэлжээ. Түүний гол хүсэлт нь Британийг ЕХ-ноос гаргах үйл явцад улс орныг хөтлөн удирдах зорилгод оршиж байв. Эрүүл мэндийн сайд Мэтт Ханкок "Тэр ирэх сонгуульд өрсөлдөх хүсэлтэй авч боломжгүй гэдгээ хэлсэн. Мэй сэтгэл хөдөлсөн байдалтай байсан" хэмээн Sky News телевизэд ярьсан байна.

Гэхдээ Ерөнхий сайдын ойрын ирээдүй тодорхой болж, түр амсхийлээ. Тэрбээр ЕХ-той тохиролцсон Брекситийн гэрээг парламентаар хэлэлцүүлэхэд ширүүн шүүмжлэлтэй тулгарах төлөвтэй байгаа. Парламентын гишүүн Маркус Фиш "Тэр ялсан нь хамаагүй. Бид түүний гэрээг дэмжихгүй. Иймээс тэр хэлцлийг цааш явуулах боломжгүй болно" хэмээн мэдэгдэв. Үүний сацуу гол сөрөг хүчин болох Лейбор нам шинээр сонгууль явуулах санаачилга дэвшүүлж, одоогийн Засгийн газарт үл итгэх асуудлыг эхлүүлэхээр төлөвлөж буй. Мэй нам дотроо ялсан авч гадны дайралтад байр суурь нь ганхаж болзошгүй.

Британи ЕХ-ноос гарахад гуравхан сар үлдээд байхад эрх баригч намынхан тэргүүндээ үл итгэх тухай санал хураалт явуулсан нь Мэйн хийсэн тохиролцоогоор Лондон ЕХ-ны худалдааны дэг журмыг дагаж мөрдөхийг зөвшөөрснийг эсэргүүцсэнээс үүдэлтэй. Түүнчлэн өнгөрсөн оны парламентын сонгуулийн үеэр хатагтай Мэй сурталчилгааны стратегийг буруу төлөвлөснөөс эрх баригчид нэлээд суудлаа алдсан гэж буруутгадаг. Консерватив намын дэд дарга Жеймс Клеверли "Тэр урьдчилсан сонгууль явуулахыг хүсэхгүй байна. Бас манай намын олон хүн ирэх сонгуульд Мэйгээр удирдуулж өрсөлдөхийг дэмжихгүй" хэмээн тайлбарлажээ. Энэ удаад Британийн Ерөнхий сайд суудалдаа үлдсэн боловч байр суурь нь нэлээд суларсан байна.

2019 онд ам.доллар унаж, иен чангарах төлөвтэй

Остин Вайнштейн

5.1 их наяд ам.долларын багтаамжтай дэлхийн валютын зах зээлийн стратегичид ирэх жил ам.доллар огцом унаж болзошгүй хэмээн таамаглаж, Японы иенд гол найдвараа тавьж байгаа аж. Долларын уналтын үндсэн шалтгаан нь 2019 оны хоёрдугаар хагаст АНУ-ын эдийн засаг уруудах хандлага байх болно гэж JPMorgan таамаглажээ.

Бусад шинжээчид Холбооны нөөц бодлогын хүүгийн өсөлтийг сааруулснаар ам.долларын ханшийг сулруулна хэмээн үзэж байна. Зах зээлийн хэлбэлзэл нэмэгдэж, гадаадад капиталын эрэлт өсөх төлөв АНУ-аас хөрөнгийн урсгал гадагш чиглэхэд нөлөөлнө гэж Morgan Stanley-ын стратегичид таамаглав.

2018 онд долларын ханш суларна гэсэн өргөн хүлээлт байсан авч Bloomberg-ийн ам.долларын индексээс харахад дөрөвдүгээр сараас өгсөж эхэлсэн.

Энэ нь Холбооны нөөцийн хүүгийн өсөлт, АНУ-ын эдийн засгийн өсөлт бусад бүсээс давсан, Хятад, Америкийн худалдааны зөрчил хурцадсан зэргээс шалтгаалсныг шинжээчид тэмдэглэв. Barclays Plc-ын Ажай Ражадхиакша зэрэг стратегичид "Ам.доллар сулрах тухай цуурхал хэрээс хэтэрлээ" гэжээ.

Тэд ногоон дэвсгэртийн солилцооны бодит ханш 2019 онд 2-3 хувиар өсөх байх гэсэн нь гол төлөв Холбооны нөөцийн бодлогын хүүгийн өсөлтөд суурилсан таамаг юм. Гэхдээ зах зээлийн байдлаас үзэхэд арилжаачид 2019 онд Холбооны нөөц хүүгээ бүрэн хэмжээгээр өсгөнө гэдэгт итгэлгүй байгаа бололтой. Сул долларын зэрэгцээ Уол Стритийн таамагт олонтоо нэрлэгдэж буй нэг мөнгөн тэмдэгт бол чанга иенийн тухай яриа юм. Ирэх оны эхний хагаст Японы төв банк Засгийн газрын бондын зах зээл дэх хяналтаа сулруулах ажиллагаа үргэлжилж, иен чангарах төлөвтэй байгаа.



Бондын ханш цааш өсөж, ханшийн ялгаа нэмэгдвэл Японы хөрөнгө оруулагчид эх орондоо мөнгө аваачих байх гэж шинжээчид бичжээ. BNP Paribas банкны стратегийн тэргүүн Даниел Кацив Японд гадаадын хөрөнгийн эрэлт 2018 онд эрүүл хандлагатай байсан авч ирэх саруудад өөрчлөгдөж болзошгүйг хагас сарын өмнө ярьсан. Тэрбээр Холбооны нөөцийн хүүгийн өсөлт АНУ-ын бондын өгөөжийг доошлуулж, Японы хөрөнгө оруулагчид ам.доллараас зайлсхийнэ гэжээ. Ноён Кацив "Иен чангарч байгаа үед Японы хөрөнгө оруулагчид гадаад валютын нөөцөө нэмэх нь юу л бол" хэмээн тайлбарласан байна.

Morgan Stanley иен дээшилнэ гэдэгтэй санал нийлж, ирэх оны сүүлээр нэг ам.доллар 102 иен болтлоо суларна хэмээн таамаглажээ. Ялангуяа Японд хувийн капиталын зарцуулалт нэмэгдэж буй үед хөрөнгө оруулагчид мөнгөө буцаан эх орондоо авчирна гэж тус банкны гадаад валютын стратегийн тэргүүн Ханс Редекер тэргүүтэй эдийн засагчид өнгөрсөн сарын 25-нд гаргасан таамагтаа бичсэн. АНУ-ын бондын өгөөж доошилсон явдал Японы хөрөнгө оруулагчдын эзэмшил дэх Америкийн урт хугацааны үнэт цаасны өгөөжийг бууруулна гэж энд дүгнэсэн байна.

2019 онд дээшлэх валютын тоонд Скандинавын орнуудын мөнгөн тэмдэгт багтаж байна. Societe Generale банкны худалдааны зөвлөмжид Норвегийн кроны ам.долларт харьцуулсан ханш өснө гэж бичжээ. Энэ нь тус улсад ажилгүйдэл доогуур, бодлогын хүү өндөр, газрын тосны үнийн өсөлт зэргээс шалтгаална гэж таамагласан байна. Түүнчлэн Шведийн төв банк бодлогын хүүгээ дээшлүүлэх төлөвтэй байгаа нь тус улсын кроныг нэлээд анхаарал татсан валют болгожээ. UniCredit банк мөн дээрх таамгийг дэмжиж байгаа авч шалтгааныг нь хоёр улсын төв банкуудын бодлогоос хамаарна гэжээ.

Uber болон Alphabet хотын тариаланд хөрөнгө оруулав

Эдний нэг ам метр талбайн гарц ижил хэмжээний энгийн газрынхнаас 100 дахин их.

Оливиа Залески

Хоёр жилийн өмнө байгуулагдсан Bowery Farming старт-ап хүлэмжид ногоо тарихдаа робот ашиглаж, өсөлтийн зам дээр гарчээ. Нью-Йоркт байрлалтай уг компани 90 сая ам.доллар босгосны дотор Uber, Alphabet компаниудаас мөнгө орж ирснийг үүсгэн байгуулагчдын нэг Ирвинг Фэйн мэдээлэв. Bowery бол шинэ ногооны технологиор ажилладаг старт-апуудын нэг бөгөөд хотын хяналттай орчинд навчит ургамал тариалдаг.

Өнгөрсөн онд Сан Францискод байрлалтай Plenty хэмээх босоо фармингийн компани Японы Softbank-ын Vision сангаас 200 сая ам.долларын хөрөнгө оруулалт авсан. Bowery мэдрэгч суулгаж, давхарласан хайрцгуудад ногоо тарьж, чийгшил, гэрэлтүүлэг, нүүрсний давхар ислийн түвшинг байнга хянадаг. Эдний нэг ам метр талбайн гарц ижил хэмжээний энгийн газрынхнаас 100 дахин их гэж мэдээлжээ. Bowery-ын бизнес төлөвлөгөө дэлхийн хүнсний дутагдлыг арилахад чиглэдэг аж.

НҮБ-ын тооцоогоор дэлхийн өсөн нэмэгдэж буй хүн амын хэрэгцээг хангахын тулд ирэх 30 жилд хүнсний үйлдвэрлэлийг хоёр дахин нэмэх шаардлагатай. Bowery болон ижил төстэй компаниуд хотуудын захад асар том битүү ферм байгуулах бизнес төлөвлөгөө боловсруулсан нь өртөг зардал ихтэй ч хаягдал багатай, шинэ ногоо нийлүүлэх боломжтой гэж үздэг. Ноён Фэйн "Энэ шатанд олон асуудал шийдэж, боломжоо ахиулж байна" гэжээ. Өнөөгийн байдлаар Bowery нийтдээ 118 сая ам.доллар босгоод байгаа.

Түүний хэлснээр Uber-ын захирал Хосровшани эдний хөрөнгө оруулагч болсон шалтгаан нь ирээдүйн хот төлөвлөлтийг сонирхдогтой холбоотой гэнэ. Bowery одоо Нью Жерсийн Кирни хотод хоёр ферм ажиллуулж байна. Энд цэцэгт байцаа, шанцай зэрэг ногоо ургуулж, Whole Foods, Sweetgreen салатны сүлжээнүүдэд нийлүүлдэг. Ноён Фэйн хэлэхдээ тэрхүү санхүүжилтийг АНУ ба гадаадад шинэ ферм барихад ашиглана гэжээ. Bowery-ын зөвлөлийн гишүүн Энди Вилер "Тус компани дэлхийн зах зээлд мэдэгдэхүйц нөлөө үзүүлэхээр бэлтгэж байна" гэв.

Эднийх ажиллагсдынхаа тоог нэмэхээр төлөвлөж байгаа аж. Одоогийн 65 ажилтан дээр Amazon-оос хүмүүс ирэх байх гэж Фэйн ярилаа. Нийгмийн сүлжээний аварга компан Нью-Йоркт шинэ оффистоо ажилтан шалгаруулж авахаа зарласан тул цахим үйлдвэрлэлийн салбарт авьяастны төлөөх өрсөлдөөн ширүүсэх бололтой. Энэ жил Bowery старт-ап Amazon Fresh, Pantry food хүргэлтийн үйлчилгээний ахлах ажилтан Брайн Донато, Amazon-ы инженерингийн менежер байсан Скотт Хорохо, өгөгдлийн төвийн захирал асан Жефф Рейнес нарыг ажилд аваад байна.

Эдийн засаг

УУЛ УУРХАЙ

Иргэн Доржийн тушаасан эрдэнэс алтны ил тод сүлжээгээр дамжсаар эх орныхоо эдийн засгийн дархлааг тэтгэж, Монголын эдийн засгийн баганыг бататгахад хувь нэмрээ оруулж байна.

С.Батсайхан / ЗГМ©

Алтны ил тод байдал хумигдаж болзошгүй

Төв банкны алт худалдан авалт 19.8 тоннд хүрчээ

Г.Байгал
@baigalZGM

МОНГОЛ

Дархан-Уул аймгийн иргэн Дорж олборлосон алтаа тушаагаад охиныхоо сургалтын төлбөрийг төлжээ. Ингэснээр намраас хойш чихнээс нь уяатай байсан нэг хонхоо чимээгүй болгосондоо Дорж додигор байна. “Сургалтын төлбөрийн дарамтаас салж санаа амарлаа.Одоо цагаан сар хүртэл их хэмжээний мөнгөний хэрэгцээ гарахгүй” хэмээн тэрбээр өгүүлж байна. Энэ намар Дархан-Уул аймагт Үнэт металлын шинэ лаборатори үүдээ нээж, үйлчилгээгээ бичил уурхайчдад илүү ойртуулсан. Ингэснээр гар аргаар алт олборлодог олон Дорж алтаа төв банкинд тушаахаар айдас тээн Улаанбаатар хотыг зорихоо больж, орон нутагтаа борлуулдаг болсон нь олборлогчдын магнайг тэнийлгэжээ.

Шинэ лаборатори иргэдээс алтыг нь Лондоны үнэт металлын биржийн ханшаар худалдан авч буй нь дэлхийн зах зээл Дарханд нүүдэллэн ирсэн гэлтэй. Энэ сарын 5-ны байдлаар тус лаборатори 107 килограмм алтыг иргэд, аж ахуйн нэгжээс худалдан авсныг төв банк мэдээлж байна. Ингэснээр орон нутагт байгуулсан Үнэт металлын шинэ лабораториуд Монгол Улсын алтны нөөцийг зутаатгахад түлхэц болсон. Мөн энэ үед төв банкны алт худалдан авалт 19.8 тоннд хүрсэн нь 2017 оныхоос 3.2 хувиар ахисан дүн.

Ингэснээр иргэн Доржийн тушаасан эрдэнэс алтны ил тод сүлжээгээр дамжсаар эх орныхоо эдийн засгийн дархлааг тэтгэж, Монголын эдийн засгийн баганыг бататгахад хувь нэмрээ оруулж байна гэсэн үг. Бичил уурхайн олборлолтын сүүдрийг сөхөж, ужгирсан асуудлыг шийдэж, зөв зохион байгуулалт оруулсан нь ийнхүү энгийн иргэдийн амьжиргааны тогтвортой эх үүсвэр болоод зогсохгүй Монголын эдийн засгийн үл ганхах баганыг тулахад чухал нөлөө үзүүлж байна гэсэн үг.

Алт тушаалт өмнөх оны мөн үеэс 3.2 хувиар өсчээ





Гэтэл нэгэн цагт иргэн Дорж Монголын эдийн засагт дэм үзүүлэх нь бүү хэл төр, засаг ч үл шийдэж чадах “шүдний өвчин”-ий нэг хэсэг болчихоод байсан нь үнэн. Дорж шиг хувиараа алт олборлогчид “нинжа” хэмээн адлуулж, нийгмээс гээгдсэн мэт амьдарч байсан. Гэтэл бичил уурхайн сүлжээний сүүдрийг сөхөж, хууль бус олборлолтыг албажуулснаар алтны салбар цэгцэрч, нийгмийн нэг “шүдний өвчин” эдийн засгийн амь болчихоод байгаа нь энэ. Дорж өдгөө нөхөдтэйгээ хоршоо байгуулж, хууль, журмын дагуу олборлолт хийдэг болсон. Ингэж албан бус олборлолтыг ил тод болгосноор уул уурхай төдийгүй экологи, эдийн засаг, нийгмийг хүлсэн гурвалсан гинжийг тасалжээ.

ЛАТИН АМЕРИК

Монгол Улс ийн албан бус олборлолтыг албажуулж буй бол бичил уурхай энэ салбарын том сүүдэр хэвээр. 1980-аад оны эхээр бичил уурхай дагасан гэрэл, сүүдэр Латин Америкийг дайрч байжээ. 20 дугаар зууны сүүлчээр эхэлсэн уул уурхайн тэсрэлт Латин Америкийн Боливи, Чили, Перу зэрэг улсыг дайрч, уул уурхай дагасан сорилтууд ар араасаа цуварчээ. Эквадор улс л гэхэд одоогоос хэдэн жилийн өмнө мөнгөн усыг хяналтаасаа алдаж, химийн энэ элементийн өмнө өвдөг сөхрөхөд хүрээд байв. Аравхан настай бяцхан хүү Чад мөнгөн усаар тоглож буй гэрэл зураг дэлхий нийтийг цочоож байсан удаатай. Тиймээс энэ асуудлыг шийдэхийн тулд Эквадор алтны бодлогоо нээлттэй болгож, хууль журмаа хөнгөвчилсөн.

Мөн Боливи, Перу улсад хүүхэд эмэгтэйчүүд уурхай дагасан хүнд хүчир ажилд үрэгдэж, алт олборлолт зах замбараагаа алдсан. Боливийн Засгийн газар, төв банкны алтны худалдааны хөтөлбөр нээснээр алтны далд худалдаачид болон Боливи-Бразилийн хил дээрх ченжийн сүлжээнд том цохилт өгчээ. Ингэснээр тус улсын хууль ёсны алтны үйлдвэрлэл 25 хувиар өсчээ. Боливи дэх алт худалдан авах түргэн үйлчилгээний цэгүүд нь том хотуудад биш уурхайн ойролцоох зам, жижиг суурин зэрэг бичил уурхайчид очиход дэд бүтцийн хүндрэлгүй газруудад чөлөөтэй нээж эхэлсэн байна.

Дэлхийн №1 эдийн засаг болох Америкийн зарим зах хязгаар нутгуудад бичил уурхайчид алт хайн тэнүүчилдэг бөгөөд аль XIX зуунд ухаж сэндийчсэн хэсгийг дахин онгичиж эхэлсэн тухай CNN агентлаг тусгай сурвалжилга хийн гаргаж байсан юм. Агуу Америкаас эхлээд Ази Африкийн олон орон өнөө хэр уул уурхайн сүүдэр болсон албан бус олборлолттой нүүр тулж байна. Ийнхүү бичил уурхайчдын тоо өсөхийн хэрээр хааж хориглохоос илүүтэй зохицуулах, ил тод байлгах, хамтран ажиллах бодлогыг дэлхийн улсууд чухалчлах болжээ.

Монгол Улс алт дагасан олборлолтыг ил болгохоор зорьсон. 2012 онд эх орны алтаар эрдэнэсийн сангаа зузаатгахын төлөө алтны нөөц ашигласны төлбөрийг бууруулж, өсөн нэмэгдэх татваргүй болгосон түүхтэй. Ингэснээр төв банкинд алт тушаах иргэн, аж ахуйн нэгжийн тоо эрс нэмэгдсэн юм. Гэтэл энэ хуулийн хугацаа улирч буй 2018 онтой хамт дуусна. Холбогдох албаныхан алтны нөөц ашигласны төлбөр 2.5 хувь байх зохицуулалтыг цааш таван жилээр сунгах санал УИХ-д өргөн барьсан. Монголын эдийн засагт амь тариа болсон энэ хуулийн хугацааг сунгах нь зүйтэй гэж бодлого тодорхойлогчид үзсэн. Гэхдээ зарим төрийн түшээ алтны татварыг өсгөх нь зүйтэй гэсэн саналыг дэвшүүлээд байна. Монгол Улс алтны татварыг өсгөөд, тус тавaарын зах зээлийг далд хэлбэрт шилжүүлж, гадаад хөрөнгө оруулагчдыг үргээж байсан гашуун түүх саяхных. Өнгөрсөн жилүүдэд алтны салбарт өрнөсөн ахиц дэвшил, Доржийн амьдралын өөрчлөлт, өсөлтийг өндөрсгөсөн татвар, журмууд салхинд хийсгэж болзошгүй юм. [ЗГМ]

ТӨЛӨВ

2019 онд тавaарын ханшид огцом савлагаа үүсэхгүй гэв

М.Золбоо
Шинжээч

Ирэх онд тавaарын зах зээлд 2015 оныхтой адил ханшийн огцом савлагаа үүсэхгүй гэж Goldman Sachs Group таамаглаж байна.

Хэдийгээр БНХАУ-ын эдийн засгийн өсөлтийн хурд саарсан ч ихэнх түүхий эдийн бизнес ашигтай байх төлөвтэйг Goldman Sachs-ийн 2019 оны төлөвийн шинэ тайланд онцолжээ. Компаниудын санхүүгийн үзүүлэлт сайжирсан, мөн үйлдвэрлэлийн хүчин чадал нэмэгдэж байгаа зэрэг нь таамаг эерэг гарах гол үндэслэл болсон аж. Үүнээс гадна аж үйлдвэрийн үндсэн түүхий эд гангийн эрэлт таван хувиар буурна гэж таамаглаж байна. БНХАУ-ын Засгийн газрын дэд бүтцийн хөрөнгө оруулалт багассан нь гол шалтгаан болно гэж Goldman Sachs-ийн шинжээчид үзжээ.

Өнгөрсөн нэгдүгээр сард тус групп БНХАУ-д гангийн нөөц 70 хүртэлх хувиар өсөж магадгүй хэмээн таамаглаж байсан юм. Хэдий тийм боловч энэ нь гангийн үйлдвэрлэлээр тэргүүлэгч Baoshan Iron & Steel компани өвлийн улирлын нийлүүлэлтийн хязгаарлалтад орох эсэхээс голлон шалтгаалах юм байна. Харин хөнгөн цагаан, нүүрсний эрэлт 2018 оны түвшинтэй ойролцоо байна гэж таамаглажээ.

ЭКСПОРТ

Зэсийн баяжмалын 0.38 хувийг Японд нийлүүлжээ

Т.Элиса
Шинжээч

Оны эхний арваннэгдүгээр сард зэсийн баяжмалын экспортын орлого 1.8 тэрбум ам.доллар болоод байна. Энэ нь жилийн өмнөхтэй харьцуулахад 26.5 хувиар өссөн гэдгийг ҮСХ мэдээллээ.

Үүний дийлэнхийг БНХАУ-ын зах зээлд, 0.38 хувийг Японд нийлүүлсэн байна. Гол экспортлогчдын нэг “Оюу Толгой” ХХК зах зээлээ төрөлжүүлэх зорилгоор Японы зах зээлд бүтээгдэхүүнээ туршилтаар гаргасан нь амжилттай болсон гэж мэдээлж байсан юм.

Харин цайрын хүдрийн экспортын орлого 183.5 сая ам.доллар бөгөөд 100 хувь БНХАУ-ын зах зээлээс олсон байна. Хэдийгээр цайрын хүдрийн экспорт биет хэмжээгээр өнгөрсөн оны мөн үетэй ойролцоо байгаа ч орлого нь 11.6 хувиар өссөн юм. БНХАУ-ын Засгийн газар байгаль орчноо хамгаалах бодлогын хүрээнд цайрын зарим уурхайгаа хаасан нь уг түүхий эдийн нийлүүлэлт тасалдаж, ханш нь огцом өсөхөд нөлөөлсөн гэдгийг “Цайрт Минерал” ХХК-ийн Ерөнхий захирал С.Батхүү онцолсон.

ЗГМ ТОВЧХОН

» АРИЛЖАА

563.3

Сая төгрөг. МХБ-ийн пүрэв гарагийн арилжаагаар нийт 31 хувьцаат компанийн 563.3 сая төгрөгийн 1,141,640 ширхэг хувьцаа арилжлээ. Арилжаагаар 14 хувьцаат компанийн хувьцааны ханш өсч, 11 хувьцаат компанийнх буурсан бол зургаа компанийн ханш тогтвортой байлаа.

» КОМПАНИ

Баасан гарагийн арилжаагаар “Адуун чулуун”, “Тахь-Ко” компанийн хувьцаа 15 хувийн өсөлтөөр тэргүүлсэн бол “Орхондалай”, “Хөх Ган” хувьцаат компанийн ханш хамгийн их уналттай байлаа.

» ЗЭЭЛ

974

Тэрбум төгрөг. Хугацаа хэтэрсэн зээлийн өрийн үлдэгдэл 2018 оны арваннэгдүгээр сарын байдлаар 974 тэрбум төгрөг болсон нь өмнөх сараас 6.7 хувиар буурсан боловч өмнөх оны мөн үеэс есөн хувиар өссөн үзүүлэлт. Хугацаа хэтэрсэн зээлийн өрийн үлдэгдэл нийт зээлийн өрийн үлдэгдлийн 5.8 хувийг эзэлж байна.

» САНХҮҮЖИЛТ

1

Их наяд вон. Өмнөд Солонгосын Засгийн газар 2022 он хүртэл Төв Ази, ОХУ, Монголын байгаль орчныг хамгаалах дэд бүтцэд зориулж нэг их наяд вон буюу 866 сая ам.долларын санхүүжилт хийхээр төлөвлөжээ.

» ТӨЛӨВ

6.1

хувь. Азийн хөгжлийн банкны суурин төлөөлөгч Ёланда Фернандез Люммен Хятадын Синьхуа агентлагт ярихдаа ирэх онд Монгол Улсын эдийн засгийн өсөлт 6.1 хувь байна гэдгийг онцолжээ.

» ТАТВАР

7.4

Их наяд төгрөг. Төсвийн урьдчилсан гүйцэтгэлээр татварын нийт орлого 7.4 их наяд төгрөг болсон нь жилийн өмнөхөөс 30.8 хувиар өссөн үзүүлэлт юм. Задалж харвал нэмэгдсэн өртгийн албан татвар 37.2, нийгмийн даатгалын орлого 22.9, онцгой албан татвар 50.1, гадаад үйл ажиллагааны орлого 35.3, бусад татвар хураамжийн орлого 25.5 хувиар тус тус нэмэгджээ.

» ЦАЛИН

1.2

Сая төгрөг. Төрийн өмчит үйлдвэрийн газар, хувьцаат компанид ажиллагчдын дундаж цалин 1.2 сая төгрөг байгаа нь улсын дунджаас 140.5-198.4 мянган төгрөгөөр илүү байна.

ВАЛЮТЫН ХАНШ

АНУ-ын доллар	2,639.21
Евро	3,003.68
Японы иен	23.33
ОХУ-ын рубль	39.70
БНХАУ-ын юань	385.55
БНСУ-ын вон	2.38

Эдийн засаг

Эдийн засгийн голлох эрсдэлийг улс төрийн тогтворгүй байдал гэв

◀1

Хэдий тийм боловч энэ байдал шинжээчдийн дүгнэлтээр урт хугацаанд үргэлжлэх боломж харагдахгүй байна. Өнгөрсөн сард инфляц улсын хэмжээнд 8.1 хувиар өсөж, шинэ оны өмнө хэрэглээний үнийн индекс төв банкны зорилтот түвшинд ирлээ. Үүний шалтгааныг шатахууны үнийн нэмэгдэл болон валютын ханштай холбон дийлэнх эдийн засагч тайлбарлаж байгаа юм. 2019 оны дотоод эрсдэлийг эдийн засагчид улс төрийн тогтворгүй байдал болон хөрөнгө оруулалтын орчинд халтай гэнэтийн шийдвэр гэж тодорхойлж байна.

Сонгуулийн өмнөх жил гэдэг утгаар гадаадын шууд хөрөнгө оруулалтыг үргээсэн, эдийн засгийн боломжоо хумьсан

Б.Хасуй / ЗГМ©

Өнгөрсөн хугацаанд зээлжих зэрэглэлээ гурван удаа сайжруулж, төсвийн орлого нэмэгдсэн ч төлбөрийн тэнцлийн алдагдал эдийн засагт томоохон дарамт болж магадгүйг эдийн засагчид сануулав.

Хөрөнгө оруулалтад халтай шийдвэр гарах эрсдэл өндөр байна

улс төрийн харалган шийдвэр 2019 онд гарах магадлал хамгийн өндөр байгаа аж. Тухайлбал, УИХ-аар хэлэлцэж буй Валютын зохицуулалтын тухай хуулийн төсөл үүний нэг бөгөөд хөрөнгө оруулагчдад сөрөг хүлээлт үүсгэсэн байна. Хэрэв уг хуулийн төсөл УИХ-аас олонхын дэмжлэг аваад энэ эрчээрээ батлагдвал гадаад зах зээлд манай улсын талаар томоохон сөрөг дохио болохоор байгаа аж. Өмнөх сонгуулийн жилүүдэд УИХ, Засгийн газрын түвшинд хөрөнгө оруулалтын орчныг дордуулсан шийдвэр гаргаснаар гадаадын шууд хөрөнгө оруулалт дөрвөн тэрбум ам.доллараас 400 сая болтлоо уруудсан нь бий. Үүнийг давтах эрсдэл одоогийн засаг, төрд ч байгааг эдийн засагчид нуусангүй.

Эдийн засгийн гадаад эрсдэлийг төсөв, мөнгөний бодлогоор дамжуулан удирдах боломжгүй. Харин өөрсдөөс хамаарах дотоод эрсдэлд тохиргоо хийх нь илүү оновчтой гэж Bloomberg TV Mongolia-ийн дэргэдэх эдийн засагчдын клубийн шинжээчид үзэж байна.

2020 оноос манай улс гадаад өрийн эргэн төлөлт хийх хуваарьтай. Энэ дагуу 2019 онд валютын нөөцөө нэмэгдүүлэх, төсвийн хөрөнгө оруулалтын зардлыг илүү үр ашигтай болгох шаардлага тулгарч байна. Төсвийн 2019 онд хүлээгдэж буй орлого тасрах эрсдэл байгаа нь тодотгол хийх хэмжээнд хүргэж мэдэх талтайг зарим эдийн засагч дурдсан юм.

ОУВС-гийн ээлжит санхүүжилт ирэх оны эхээр орж ирэх хүлээлттэй байна. 2020 онд төсөв бэлэн үү гэсэн асуулт Сангийн яам болон мөнгөний бодлогыг залуурдах төв банк руу чиглэж буй. Өнгөрсөн хугацаанд зээлжих зэрэглэлээ гурван удаа сайжруулж, төсвийн орлого нэмэгдсэн ч төлбөрийн тэнцлийн алдагдал эдийн засагт томоохон дарамт болж магадгүй байна. 2018 оны хувьд манай улс ОУВС-гийн хөтөлбөрийн хүрээнд 850 орчим сая ам.долларын санхүүжилт авахаар байсан ч үүний дөрөвний нэг хүрэхгүй хэсэг нь эдийн засагт орж ирсэн байна.

Ирэх оны эдийн засгийн дараагийн хүлээлт уул уурхайн салбарт хамаарч байгаа юм. Энэ нь "Эрдэнэс Тавантолгой"-н IPO. Тус компани ирэх оны хоёрдугаар улиралд багтаж олон улсын хөрөнгийн зах зээлд гарахаар төлөвлөж байгаа. Ингэснээр нийт хувьцааныхаа 30 хүртэлх хувийг хөрөнгө оруулагчдад санал болгосноор гурав орчим тэрбум ам.долларын хөрөнгө босгохоор бэлтгэл ажил нь үргэлжилж байгаа билээ. Тэгвэл үүнийг Bloomberg TV Mongolia-ийн дэргэдэх эдийн засагчдын клубийн энэ оны тав дахь уулзалтад оролцсон эдийн засагч Ч.Отгочулуу "Бодит нөхцөл байдлаа авч үзвэл 30 хувиа гаргаад гурван тэрбум ам.доллар босгох бараг л боломжгүй. Жишээ нь, "Эрдэнэс Тавантолгой" компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн томилгоо, компанийн засаглал, гэрээний ил тод байдал хөрөнгө оруулагчдад хувьцааг нь авах хэмжээний итгэл үнэмшил төрүүлэх түвшинд биш байна" гэж дүгнэсэн юм.





Монголбанк©

"Өргөтгөсөн санхүүжилтийн хөтөлбөр"-ийн хүрээнд төсвийн дэмжлэг болгох үүднээс Дэлхийн банк манай улсад хөгжлийн бодлогын хоёр дахь зээлээ 2019 оны эхээр олгохоор төлөвлөж байна. Он гарсаар валютын орох урсгал дээрх байдлаар нэмэгдэх бол нөгөө талд БНХАУ-ын Ардын банктай Монголбанкны байгуулсан своп хэлцлийн эргэн төлөлт хийгдэхээр байна. 2014 онд байгуулсан своп хэлцлийн хугацаа ирэх оноор дуусгавар болж байгаа юм.

Хоёр улсын Засгийн газрын түвшинд гадаад худалдааны эргэлтийг ирэх онд 10 тэрбум ам.долларт хүргэх зорилтын биелэлтийг дүгнэхээр байгаа. Тус улстай хийж буй манай улсын нүүрсний экспортын биет хэмжээ арваннэгдүгээр сарын байдлаар өмнөх сартай харьцуулахад 38 хувиар буурсан үзүүлэлттэй байна. Гол түүхий эд болох нүүрсний үнэ дунджаар 14 ам.доллараар буурах эрсдэл байгаа аж.

Засгийн газрын төсвийн тэлэлт ирэх онд импортыг 40 орчим хувиар нэмэгдүүлэх хүчин зүйл болоод зогсохгүй хэрэглээг илт дэмжих хандлага давамгайлж байна. Монголбанкны хэрэглээний зээлийг хумих, нөгөө талдаа бизнесийн зээлийг нэмэх шийдвэр ирэх оноос хэрэгжиж эхлэх бөгөөд энэ нь санхүүгийн салбарын тогтвортой байдлыг онилж буй. Төгрөгтэй харьцах ам.долларын нэрлэсэн ханш чангарах тусам манай улсын гадаад өр, төлбөрийн хэмжээ өсөн нэмэгдэх эрсдэл байгааг Сангийн дэд сайд Х.Булгантуяа өгүүлсэн юм. [ЗГМ]

ХАМТЫН АЖИЛЛАГАА

Арнауд Суарат: Тавантолгойн цахилгаан станц барихад Засгийн газартай ойлголцох асуудлууд олон байна

Э.Эрдэнэтуяа
Шинжээч

"Рио Тинто" группийн Зэс, очир эрдэнийн группийг тэргүүлэгч Арнауд Суарат "Тавантолгойн цахилгаан станц барих талаар Монгол Улсын Засгийн газартай ойлголцох асуудлууд байгаа" гэж "Эрдэнэс Монгол" компанийн удирдлагуудтай уулзах үеэрээ онцоллоо. "Хэрэв талууд ойлголцолд хүрч чадвал ойрын хугацаанд хэлэлцээрт гарын үсэг зурж, бүтээн байгуулалт эхлүүлэх боломжтой" хэмээн тэрээр мэдэгдсэн аж. "Эрдэнэс Монгол" ХХК-ийн Гүйцэтгэх захирал П.Ганхүү "Оюутолгойн ордын эрчим хүчийг дотоод эх үүсвэрээс хангах нь хамгийн оновчтой хувилбар" хэмээсэн байна. Мөн жилд худалдан авах цахилгаан эрчим хүчний хэмжээ, үнэ тарифыг тодорхой болгож, баталгаа гаргаж өгвөл талуудын хэлэлцээр амжилттай болно гэдгийг уулзалтын үеэр онцолжээ.

ЗАХ ЗЭЭЛИЙН ГОЛ ҮЗҮҮЛЭЛТ:

АПУ ХК



Өдөр ↑3.50% Сар ↓ Жил ↓

МОНГОЛ ШУУДАН ХК



Өдөр ↓0.01% Сар ↓ Жил ↓

ТАВАН ТОЛГОЙ ХК



Өдөр ↓0.70% Сар ↑ Жил ↑

СҮҮ ХК



Өдөр ↓5.90% Сар ↑ Жил ↓

Turquoise Hill Resources Ltd Торонто



Өдөр ↓3.85% ↓Сар ↓Жил

Erdene Resource Development Торонто



Өдөр ↑2.27% Сар ↑ Жил ↓

Aspire Mining Австрали



Өдөр ↓5.00% Сар ↓ Жил ↑

Rio Tinto Австрали



Өдөр ↑1.67% ↑Сар Жил ↓

DOW JONES	S&P 500	FTSE 100	NIKKEI 225	TOPIX	SHANGHAI COMPOSITE	HANG SENG	KOSPI
0.22%	0.036%	1.06%	2.15%	1.99%	0.31%	1.61%	1.44%